



**ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР**

БАВУУДОРЖИЙН БҮЖИНЛХАМ

/Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн/

**ЗАЛУУ ГЭР БҮЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ,
ХЭРЭГЦЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭ**

/Дундговь аймгийн жишээн дээр/

УЛААНБААТАР 2022 ОН

Талархал

Энэхүү судалгааг боловсруулахад дэмжиж ажилласан Дундговь аймгийн Засаг Даргын Тамгын газар, Нийгмийн бодлогын хэлтэс, Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Сумдын засаг дарга нар, нийгмийн бодлогын мэргэжилтнүүд нарт талархал илэрхийлье.

Хураангуй

Гэр бүл нь сэтгэл зүй, ёс суртахуун, эдийн засаг, эрх зүй зэрэг нийгмийн олон төрлийн харилцааг өөртөө багтаасан өвөрмөц орчин байдаг. Олон улсын гэрээ, конвенцуудад гэр бүлийг нийгмийн анхдагч нэгж хэмээн заасан байдаг нь гэр бүлийн бүтэц, гэр бүлийн тухай ойлголт, хандлага, нийгмийн хөгжлийн зүй тогтлын дагуу өөрчлөгдөн, улам боловсронгуй болж байх жамтайг хүлээн зөвшөөрсний итгэл юм.

Дундговь аймгийн залуу гэр бүлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг судлах, тэдний хэрэгцээ шаардлагад үндэслэн залуу гэр бүлд чиглэсэн үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор уг судалгааг боловсруулсан билээ. Судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд

- Залуу гэр бүлийн талаарх онолын үзэл баримтлалыг судлах
- Залуу гэр бүлийн амьдралд нөлөөлж буй нийгэм эдийн засаг, улс төрийн хүчин зүйлс, төрөөс баримталж буй бодлого
- Залуу гэр бүлийн амьжиргаа, харилцаа, сэтгэл зүй, эрүүл мэндийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал
- Залуу гэр бүлийн хэрэгцээ, хэрэгцээ шаардлагад үндэслэн залуу гэр бүлд чиглэсэн үйлчилгээг нэмэгдүүлэх юм.

Судалгаанд Дундговь аймгийн нийт өрхийн 5.5 хувь буюу 805 өрхийг хамруулж, нарийвчилсан дүн шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.

Энэхүү судалгааны ач холбогдол нь нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд шинэчлэл хийж, гэр бүлд зарцуулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, гэр бүлийн гишүүдийг бэлэнчлэх бус өөрсдийн нөөц чадавхид тулгуурлан хөгжүүлэх, гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих төрийн бодлого, үйлчилгээ хэрэгцээтэй байгааг тодорхойлсон юм.

Түлхүүр үг: Залуу гэр бүл, тулгамдаж буй асуудал, хэрэгцээ, үйлчилгээ, дундговь аймаг, гэр бүл саллалт

АГУУЛГА

УДИРТГАЛ

- Судалгааны үндэслэл, тулгамдсан асуудал
- Судалгааны асуулт
- Судалгааны ажлын зорилго, зорилтууд
- Судалгааны хамрах хүрээ
- Судалгааны ач холбогдол

БҮЛЭГ 1 : Залуу гэр бүлийн онолын талаарх зарим асуудал

- 1.1 Залуу гэр бүлийн талаарх ойлголт, онолын үзэл баримтлал
- 1.2 Залуу гэр бүлийн сэтгэл зүй, нийгмийн харилцааны онцлог

БҮЛЭГ 2: Судалгааны арга зүй

- 2.1 Судалгааны зорилго, зорилт, таамаглал
- 2.2 Судалгааны загвар ба аргачлал
- 2.3 Мэдээлэл цуглуулах процесс, аргачлал, арга хэрэгслүүд

БҮЛЭГ 3: Залуу гэр бүлийн эдийн засаг, амьжиргаа, харилцаа, сэтгэл зүй, эрүүл мэндийн өнөөгийн нөхцөлд байдалд хийсэн дүн шинжилгээ /Дундговь аймгийн жишээн дээр/

- 3.1 Дундговь аймагт залуу гэр бүлийн талаар баримталж буй бодлого
- 3.2 Залуу гэр бүлийн нийгэм, хүн ам зүй, эдийн засгийн ерөнхий төлөв байдал
- 3.3 Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, хэрэгцээ, үйлчилгээ

БҮЛЭГ 4: Үр дүн

БҮЛЭГ 5: Ерөнхий дүгнэлт

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

ХАВСРАЛТ

УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл, тулгамдсан асуудал:

Өрх гэр бүл нь хүний хөгжил төлөвшлийн анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж, соёл, зан заншил, уламжлал өвлөгдсөн шинэчлэгдэх, аж төрөх ёсны бичил ахуй билээ. Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогод “Гэр бүл нь хүний амьдарлын анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж гэж үзэж, түүний хөгжлийн тухай асуудлыг төрийн бодлогын анхааралд байлгана” гэж заасан нь өнөөгийн төр, засгаас гэр бүлийн талаар баримтлах бодлогын үндэс болж байна.

Гэр бүлийн харилцааны өнөөгийн хэв маяг, хөгжил, өөрчлөлт, цаашдын чиг хандлага, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох зорилготойгоор 2010-2011 онд “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” суурь судалгааг хийсэн байдаг. Судалгаанаас үзэхэд ойрын 5-10 жилд манай оронд өрх гэр бүлийн харилцааны асуудал улам нарийсан төвөгтэй болж, шийдвэрлэх асуудлууд дэвшин гарч ирэх хандлага ажиглагдаж буйг дурджээ. Мөн архидалт, ядуурал, үнийн хөөргөдөл, мөнгөний ханшны уналт, шилжих хөдөлгөөн, гадаадад гарч ажиллах, даяаршил зэрэг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс гэр бүлийн зөрчилд нөлөөлдөг гэж үзсэн.¹ Судлаач Б.Оюун-Эрдэнийн үзэж байгаагаар “Монгол улсад явагдсан нийгмийн шилжилтийн үе болон дэлхий дахины даяарчлал, соёлын глобалчлал нь монгол гэр бүлийн бүтэц, хэв маягт ихээхэн өөрчлөлтийг авчирч байна.”²

“Өрх, гэр бүлийн байдал, гэрлэлт” сэдэвт 2010 онд хийгдсэн судалгаанд ажилгүйдэл, архидалт, амьжиргааны доройтол нь гэр бүлийн доторх харилцаанд таагүй нөлөөлж, гэр бүл салахад нөлөөлсөөр буйг тэмдэглэжээ.³ Дундговь аймгийн суурин хүн амын тоо 2020 оны жилийн эцсийн байдлаар 47274 болж өнгөрсөн оноос 837 хүнээр нэмэгдэж, жилийн дундаж өсөлт 1.8 хувь болжээ. Хүн амын дийлэнх буюу 30.6 хувийг залуучууд эзэлж байна.

Дундговь аймагт 2020 он жилийн эцсийн байдлаар 172 гэрлэлт бүртгэгдсэн нь өмнөх оноос 11.0 хувиар буурсан бол, цуцлалт 35 бүртгэгдсэн өмнөх оноос 19 хувиар буурсан байна. Сүүлийн 5 жилийн статистик дунджаас харахад жилд дунджаар гэрлэлт 1.1 хувиар

¹ ШУА-ийн ФСХ, УБИС Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, Улаанбаатар: 2010

² “Монгол гэр бүлийн бүтэц, хэв маяг, харилцааны онцлог, тулгамдаж буй асуудал” //Шинжлэх ухааны академийн мэдээ. 2012 он №03, хх. 37-49

³ 1212.mn

буурсан, гэрлэлт цуцлалт 3.1 хувиар нэмэгдсэн байна.³ Сүүлийн жилүүдэд гэр бүл цуцлалт нэмэгдэж, залуужих хандлагатай байна гэсэн дүгнэлтийг аймгийн статистикийн хорооноос гаргасан байна.

Гэр бүл цуцлалт нь 2016 оноос өсөх хандлагатай байгаа бөгөөд гэр бүлийн маргаантай асуудлыг шийдвэрлэж буй шүүхийн статистик тоон мэдээллээс үзэхэд:⁴

2016-2020 онд нийт 185 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан, түүнчлэн гэр бүл байсан хугацаагаар авч үзэхэд 1-3 жил амьдарсан гэр бүл 32, 4-6 жил амьдарсан 37 гэр бүл, 7-9 жил амьдарсан 48 гэр бүл, 10-аас дээш жил амьдарсан 68 гэр бүл байна. Үүнээс үзэхэд 7-оос дээш жил хамт амьдарсан гэр бүлийн цуцлалт нь 62.7 хувийг эзэлж байна. Түүнчлэн гэрлэлт цуцлуулсан гэр бүлийг насны хувьд авч үзэхэд 18-35 насны гэр бүл 57 хувь, 35-49 насны гэр бүл 41 хувь, 50-аас дээш насны гэр бүл 2 хувь байна. Үүнээс үзэхэд залуу гэр бүлийн цуцлалт их байгаа нь энэхүү статистик тоон мэдээллээс харагдаж байна.

Улс орнууд залуу гэр бүлд ихээхэн анхаарч ирсэн бөгөөд тэдэнд тулгарсан асуудлыг шийдэх олон талт аргууд, шинэ санаанд тулгуурласан хөтөлбөрийг хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрч байна. Тухайлбал, хүүхдэд үзүүлэх халамжийн хөтөлбөр, гэрлэлт болон салалтын талаарх бодлого, бага орлоготой гэр бүлийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, оюутан гэр бүлд үзүүлэх тусламж зэрэг болно. Зарим улс орнуудын туршлагыг авч үзвэл:⁵

- АНУ нь залуу гэрлэсэн хосуудад олгох тэтгэлэг, эцгийн хариуцлагын тэтгэмж, оюутанд олгох зээл, богино хугацааны тусламж дэмжлэг үзүүлэх, хөтөлбөр /хүүхэд асрахад тусалцаа үзүүлэх, хөдөлмөрт бэлтгэх гэх мэт/, шинээр гэрлэсэн оюутнуудад олгох сургуулийн тэтгэлэг зэрэг болно.
- Франц улс нь дотоодын нийт бүтээгдэхүүний орлогын 3 хувийг гэр бүлийн бодлогод зарцуулдаг. Залуу гэр бүлд гэр бүлийн хөгжил, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн, өрх толгойлсон эцэг, эхчүүдийн, орон байрны, олон хүүхэдтэй гэр бүлийн, бага насны хүүхэд асрах зэрэг тэтгэмжүүдийг олгодог байна.

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 16 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”-д гэр бүлийн амьдарлын төвшинг тасралтгүй дээшлүүлж, гэр бүлийн харилцаа, ёс зүйн эрүүл орчин, түүний нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх таатай нөхцлийг бүрдүүлэх замаар монгол хүний хөгжлийг

⁴ Дундговь аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016-2020 оны статистик мэдээлэл

⁵ УИХ, Залуу гэр бүлийг дэмжих төрийн бодлогын талаар бусад орны зохицуулалт, эрх зүйн орчны асуудал /харьцуулсан судалгаа/ Улаанбаатар:2013

дэмжихэд энэхүү бодлогын эрхэм зорилго оршино гэж тодорхойлжээ.⁶ Үүнтэй холбоотой манай оронд өрх, гэр бүлийн асуудлыг төрийн хэмжээнд ихээхэн анхаарч, гэр бүлийг төрөөс хамгаалах, түүний хөгжлийн таатай орчин нөхцлийг бүрдүүлэх талаар хууль эрх зүй, бодлогын цөөнгүй баримт батлагдан мөрдөгдөж байна.

Дээрх гэр бүлийн талаар баримтлах бодлогоос залуу гэр бүлрүү чиглэсэн зорилтын хэрэгжилтийг харвал 4-р бүлгийн 6-р зүйл дээр “Залуучуудын гэр бүлийн талаарх мэдлэг, ойлголт, хандлагыг судалж, уламжлал, шинэчлэлийн асуудлаар хэлэлцүүлэг, ярилцлага зохиох” гэж дэвшүүлсэн зорилт нь өнөө үед үр дүнгээ хангалттай сайн өгсөн хэдий ч “Залуу гэр бүлийг орон сууцтай болохыг дэмжих хөнгөлөлттэй, урт хугацаатай зээлийн сан, түрээс, лизингийн үйлчилгээ, оюутны, гэр бүлийн, хүүхдэд зориулсан сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагыг хөгжүүлэх зэргээр залуу гэр бүлд нийгмийн таатай орчин бүрдүүлэх” гэж заасан байдаг нь бодит байдал дээр өнөөдрийг хүртэл бүрэн биеллээ олоогүй учир дутагдалтай байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх зорилгоор “Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийг 2018-2021 онуудад хэрэгжүүлж ажилласан.

Дундговь аймгийн хэмжээнд Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрт 15 сумын 270 өрхийн 1046 гишүүн, 0-18 хүртэлх насны 499 хүүхэд, үүнээс эрсдэлт нөхцөлд амьдарч буй 33 хүүхэд байна. Өрхүүдийг 11 хэв шинжээр сонгож хөтөлбөрт хамруулсан бөгөөд тэдгээрийн 3.3% шилжин суурьшсан гэр бүл, 4% нь түр хугацаагаар тусдаа амьдарч буй гэр бүл, 12.9% хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн иргэнтэй гэр бүл, 7.4% хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүл, 10% дахин гэрлэсэн гэр бүл, 20% архины хамааралтай гэр бүл, 8.1% хүчирхийллийн харилцаатай, 25% ядуу гэр бүл, 12.2 хувь эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхэдтэй гэр бүл, 3.3% хорих ангид ял эдэлж байгаа гэр бүл, 5.9% өрөөсгөл гэр бүл тус тус байна. Үүнээс залуу гэр бүл 39%, дунд насны гэр бүл 33%, ахмад насны гэр бүл 28%-ийг тус тус эзэлж байна.

Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн хүрээнд сонгогдсон 270 өрхтэй ажиллаж, үйлчилгээнд хамруулсны дараах явцын үнэлгээг хийхэд хөтөлбөрт хамрагдсан гэр бүлийн 60% буюу 162 өрхийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, нийгмийн суурь үйлчилгээнд хамруулсан бол үлдсэн 40 хувь буюу 108 өрхийн тулгамдсан асуудлыг бүрэн

⁶ УИХ-ын 16-р тогтоолын хавсралт, 2003 он, “Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”

шийдвэрлэж чадаагүй байна. Иймд дундговь аймгийн залуу гэр бүлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг судлан, тэдний хэрэгцээ шаардлагад үндэслэн залуу гэр бүлийг дэмжих хөтөлбөр боловсруулах шаардлага байна.

Судалгааны асуулт:

Зорилго: Дундговь аймгийн залуу гэр бүлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг судлах, тэдний хэрэгцээ шаардлагад үндэслэн залуу гэр бүлд чиглэсэн үйлчилгээг үйлчилгээг нэмэгдүүлэх

Сайн байна уу. Танд энэ өдрийн мэнд хүргье. Энэхүү судалгааг үнэн зөв, бүрэн гүйцэт хариулна гэдэгт итгэж байна.

Нэг: Залуу гэр бүлийн нийгэм, хүн ам зүй, эдийн засгийн төлөв байдал

1. Таны хүйс

- Эр
- Эм

2. Боловсролын байдал:

- Боловсролгүй
- Бага боловсрол
- Бүрэн бус дунд
- Бүрэн дунд
- Техник мэргэжлийн
- Бакалаврын дээд
- Магистр, доктор

3. Гэрлэлтийн байдал:

- Гэрлэлтийн баталгаатай
- Гэрлээгүй, хамтран амьдарч байгаа
- Салсан
- Бэлэвсэн

4. Таны нас.....

5. Ам бүлийн тоо.....

6. Ажил эрхэлдэг хүний тоо.....

7. 0-18 нас хүртэлх хүүхдийн тоо.....

8. Гэр бүлийн дундаж орлого.....

9. Малын тоо толгой.....

10. Гэр бүлийн үнэт зүйлээ эрэмбэлэнэ үү. (1-13 хүртэлх тоо)

- Эрүүл мэнд
- Үр хүүхэд
- Гэр бүлийн амар амгалан бат бөх амьдрал
- Боловсрол
- Шударга ёс
- Ажил мэргэжил
- Хүний эрх
- Найз нөхөд
- Эд хөрөнгө
- Авъяас чадвар
- Нэр нөлөө бүхийн танил тал
- Алдар цол, нэр хүнд

11. Залуу гэр бүлд нөлөөлж буй хүчин зүйлс /Тайлбар: 1-огт нөлөөлөхгүй, 2-нөлөөлөхгүй, 3-дунд зэрэг, 4-ер нь нөлөөлнө, 5 маш их нөлөөлнө./

- Бүх шатны төрийн үйлчилгээний хүнд суртал, авлига
- Хууль тогтоомжийн тогтворгүй байдал
- Өр зээл
- Бэлчээр, байгалийн нөөцийн доройтол
- Хүнсний аюулгүй байдал
- Ажилгүйдэл
- Ядуурал
- Архидалт
- Жендэрийн хэвшмэл ойлголт
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
- Баян хоосны ялгаа

- Боловсролын чанар хүртээмж
- Намуудын талцал
- Шударга ёс
- Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт

Хоёр. Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, хэрэгцээ

12. Залуу гэр бүлийн эдийн засаг, амьжиргааны байдал /Тайлбар: 1-маш муу, 2-муу, 3-дунд зэрэг, 4-сайн, 5-маш сайн./

- Хоол хүнс тэжээл
- Амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх байдал
- Өрхийн сууцны байдал
- Амьжиргааны түвшин
- Нийгмийн даатгал
- Халамжийн тэтгэмж
- Амьдрах таатай орчин
- Хүүхдийн суралцах нөхцөл
- Цалин, орлого
- Гэр бүлээрээ баяр ёслол, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх байдал
- Бизнес эрхлэх боломж
- Газар өмчлөх эрхээ эдлэх боломж

13. Залуу гэр бүлийн харилцааны нөхцөл байдалд тулгамдаж буй асуудал (Тайлбар: 1-маш муу, 2-муу, 3-дунд зэрэг, 4-сайн, 5-маш сайн)

- Эхнэр, нөхрийн харилцаа
- Ээж, хүүхдийн харилцаа
- Аав, хүүхдийн харилцаа
- Эцэг, эх багшийн харилцаа
- Үе тэнгийхний харилцаа
- Хүүхэд багштайгаа харилцах харилцаа
- Хадам аав ээжтэйгээ харилцах харилцаа
- Хамаатан садантай харилцах харилцаа
- Найз нөхөдтэйгээ харилцах харилцаа
- Ханийн хайр халамж

14. Залуу гэр бүлийн сэтгэл зүйн байдал: (Тайлбар: 1-маш муу, 2-муу, 3-дунд зэрэг, 4-сайн, 5-маш сайн)

- Өөртөө итгэлгүй, идэвхгүй байдал
- Үрэлгэн зан
- Хоол, амралтын буруу зуршил
- Залхуу хойрго
- Эрүүл мэндээ, биеэ үл хайхрах
- Тооцоо төлөвлөөгүй байдал
- Стресс бухимдал
- Санаа зовнил
- Сэтгэл гутрал
- Айдас түгшүүр

15. Залуу гэр бүлийн эрүүл мэндийн одоогийн нөхцөл байдлыг дүгнэнэ үү. (Тайлбар: 1-маш муу, 2-муу, 3-дунд зэрэг, 4-сайн, 5-маш сайн)

- Суурь өвчлөл
- Эрүүл хүнсний хэрэглээ
- Эмнэлгийн үзлэг, шинжилгээнд хамрагдалт
- Эмийн хэрэглээ
- Бэлгийн замын халдварт өвчин
- Дасгал хөдөлгөөн, спортоор хичээллэх байдал
- Компьютер утасны хэрэглээ
- Амин дэмийн хэрэглээ

Эксперт ярилцлагын асуултууд

Асуулт 1: Залуу гэр бүлд ямар төрлийн нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ хэрэгтэй вэ? Үүний ач холбогдол юу вэ? Үүнийг нэрлэнэ үү. /Сэтгэл зүйч, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага/

Асуулт 2: Залуу гэр бүлийн харилцааны нөхцөл байдал юунаас шалтгаалж зөрчилдөж байна вэ?, цаашид юун дээр анхаарах ёстой вэ? Ямар төрлийн дэмжлэг үзүүлэх вэ?

Асуулт 3: Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэхэд ямар төрлийн дэмжлэгийг орон нутгийн зүгээс үзүүлэх шаардлагатай вэ?

Асуулт 4: Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэхэд ямар төрлийн дэмжлэгийг орон нутгийн зүгээс үзүүлэх шаардлагатай вэ?

Асуулт 5: Залуу гэр бүлтэй ажиллахад нийгмийн ажилтны арга зүйг ашигладаг уу?

Судлагдсан байдал:

Ерөнхий утгаараа залуу гэр бүлийг судалсан судалгаа нилээдгүй байгаагаас “Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам”-ны санаачилгаар хийгдсэн “Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” суурь судалгаа 2004, 2010, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын захиалгаар хийсэн “Монголын гэр бүлийн асуудал, хэрэгцээ үйлчилгээний хувилбар” суурь судалгаа 2018 онд тус бүр хийгдсэн байна. Үүний үргэлжлэл болгон 2018 онд “Монгол гэр бүлийн харилцааны хэв шинж өөрчлөлт” нэртэйгээр суурь судалгааг үргэлжлүүлэн хийсэн байна. Эдгээр суурь судалгаанууд нь гэр бүлийн орчин үеийн хэлбэр өөрчлөлт, гэр бүл тулгамдаж буй асуудал, зөрчил маргаанд нөлөөлж буй шалтгаан зэрэг гэр бүлийн олон чухал асуудлыг нэгтгэн, өргөн утгыг агуулсан судалгаа болсноор барахгүй олон судалгааны эх сурвалж болж байна.

Б.Оюун-Эрдэнэ “Монгол гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт” (2018) судалгааныхаа хүрээнд залуу гэр бүлийн өмнө тулгамдаж буй зарим асуудлыг тодруулах мөн ямар төрлийн дэмжлэг илүү хэрэгцээтэй байгааг тодорхойлсон байгаа юм. Үүнд: Төрөөс ямар төрлийн дэмжлэг авахыг илүүтэй хүсдэгийг тодруулахад залуу гэр бүлүүдийн (53.3) 50.8 нь ажлын байраар хангах, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх (23.5%) 22.5 нь, харин боловсрол, мэргэжлийн түвшингээ ахиулах (14.4%) 3.2% гэсэн эдгээр 3 хувилбарт хамгийн өндөр хувиар судалгаанд хамрагдсан залуу гэр бүлүүд хариулсан байна. Уг судалгааны дүгнэлтэд гэр бүлүүд төр, засгаас зохицуулалт хийн дэмжин ажиллахыг хүссэн гол асуудал бол гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг өсгөж, ажлын байраар хангах явдал хэмээн дүгнэсэн байна.

Мөн залуу гэр бүлийн тулгамдаж буй асуудлын талаар эрдмийн зэрэг горилсон бүтээлүүд хэд хэд байгаагаас онцлон дурдвал:

- Г.Батцэцэг “Залуу гэр бүлийн харилцаанд тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх нь” 2010 он, магистрийн зэрэг горилсон бүтээл

- Б.Мөнх-Оч “Залуу гэр бүлд тулгамдаж байгаа нийгмийн асуудал болон түүнийг шийдвэрлэхэд төрөөс баримталж буй бодлогын нийцэл” 2021 он, бакалаврын зэрэг горилсон бүтээлүүд байна.

Харин тухайлан залуу гэр бүлийн асуудал, хэрэгцээг тодорхойлж, гэр бүлийг дэмжих хөгжлийн хөтөлбөр боловсруулсан судалгаа хомс байна.

Судалгааны зорилго:

Дундговь аймгийн залуу гэр бүлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг судлах, тэдний хэрэгцээ шаардлагад үндэслэн залуу гэр бүлд чиглэсэн үйлчилгээг нэмэгдүүлэх

Судалгааны зорилт:

- Залуу гэр бүлийн талаарх онолын үзэл баримтлалыг судлах
- Залуу гэр бүлийн амьдралд нөлөөлж буй нийгэм эдийн засаг, улс төрийн хүчин зүйлс, төрөөс баримталж буй бодлого
- Залуу гэр бүлийн амьжиргаа, харилцаа, сэтгэл зүй, эрүүл мэндийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал
- Залуу гэр бүлийн хэрэгцээ, хэрэгцээ шаардлагад үндэслэн залуу гэр бүлд чиглэсэн үйлчилгээг нэмэгдүүлэх

Судалгааны объект:

- Дундговь аймгийн залуу гэр бүлүүд
- Орон нутгийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, өмгөөлөгч, цагдаа, шүүхийн асуудал хариуцсан мэргэжилтэнгүүд, сумдын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтнүүд

Судалгааны шинэлэг тал: Дундговь аймгийн хэмжээнд залуу гэр бүлрүү чиглэсэн судалгааны ажил хомс байна. Тиймээс энэхүү судалгаа маань залуу гэр бүлийн өмнө тулгамдаж буй асуудлыг судалж, түүндээр суурилсан хөтөлбөр боловсруулж байгаа нь судалгааны шинэлэг тал болно.

Судалгааны ач холбогдол:

Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудлыг судалж, хэрэгцээг тодорхойлсноор, орон нутгийн зүгээс залуу гэр бүлрүү чиглэсэн үйл ажиллалааг зохион байгуулах, үндэслэл, онол практикийн ач холбогдолтой.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАЛУУ ГЭР БҮЛИЙН ТАЛААРХ ОНОЛЫН ЗАРИМ АСУУДЛУУД

1.1 Залуу гэр бүлийн талаарх ойлголт, онолын үзэл баримтлал

Гэр бүл нь аливаа нийгмийн бүрэлдүүлж байгаа анхдагч нэгж бөгөөд гэр бүлийн тогтвортой, зөрчилгүй, тайван байдал нийгмийн амьдралд эерэгээр нөлөөлдөг. Гэр бүлийн социологчид, нийгмийн ажилтан, гэр бүл судлаачид, сэтгэл зүйчид зэрэг нийгмийн шинжлэх ухааны олон салбарт судалдаг.

Философичид гэрлэлт, гэр бүлийн асуудлыг тухайлан авч үзээгүй ч анхаарлын гадна орхиогүй юм. Тухайлбал, эртний грекийн философич Платон, Аристотель, Аристип, Эпикур нар гэр бүлийн мөн чанар, гэр бүлийн жам ёсны асуудлыг өөр өөрийн байр сууринаас тайлбарлаж иржээ. Гэр бүлийн асуудлыг анх удаа онцлон авч үзсэн хүн бол эртний грекийн философич Платон юм. Платон гэр бүлийн талаарх үзлээ “Төр улс” зохиолдоо нэлээд өвөрмөц байдлаар илэрхийлсэн бөгөөд “гэр бүл бол нийгмийн анхдагч үүр, өөрчлөгдөшгүй зүйл бөгөөд гэр бүлүүдийн нэгдлийн үр дүнд төр улс бий болсон”⁷ гэж үзжээ. Ийнхүү эртний грекийн философичдоос үүсэлтэй гэр бүлийн талаарх патриархал үзэл нь олон үеийн турш философичдын үзэл санааны онолын үндэслэл болж байсан төдийгүй нийгмийн үзэл санаанд хүчтэй ноёрхож байсан байна. Тухайлбал: Францын соён гэгээрүүлэгч Жан Жак Руссо “хамгийн эртний нийгмээс эхлээд бүх нийгэмд байсан цорын ганц зүйл бол “Гэр бүл” юм. Хэрвээ гэр бүл хэрэгтэй гэж үзвэл улс төрийн нийгмийн ирээдүйн дүр зураг, эрх баригч нь эцэг, эх ард түмэн нь хүүхдүүдтэй төсөөтэй юм гэсэн эртний грекийн философичдын гэр бүл гэх засаглалын хэлбэрийн үзэл санааг баримтлагч байсны тод илрэл юм.

Гэр бүл гэдэг ухагдахууныг социологийн шинжлэх ухаанд “гэрлэлт, үрчлэлт, цусан төрлийн холбоогоор холбогдож, харилцан үүрэг хүлээж, туслалцан дэмжлэг, нэгдмэл ахуй амьдралын бүлэг хүмүүсийн нэгдэл” хэмээн ойлгож, тайлбарладаг⁸.

Социологийн шинжлэх ухааныг үндэслэгч Огюст Кант (1798-1857он) нийгэм нь гэр бүлүүдийн цогц нийлбэрүүдээс бүтнэ гээд “Гэр бүл бол харилцан таалагдах, татагдах мэдрэмж дээр суурилсан сэтгэл зүйн холбоо хамаарал” юм гэж тодорхойлжээ.

⁷ Платон.Законы Соч.в 3 т. М.1972.т. 3. Ч. Стр. 148-150

⁸ Гэр бүлийн социологи.Бүрэнжаргал,Т (2005)Уб.7-р тал

Онолын үзэл баримтлалууд нь гэр бүлийг янз бүрээр тодорхойлдог. Ерөнхийдөө гэр бүлийн талаарх ойлголтыг тайлбарладаг онолуудад билэг тэмдэг, харилцан үйлчлэлийн онол, Бүтэц үүргийн онол, Зөрчилдөөний онол, Солилцооны онол, Феминизмийн онол, Постмодернист онолууд багтдаг байна.⁹

Онолоор гэр бүлийг нийгмийн нэг бүлэг гэж үзээд хувь хүн нь гэр бүл, нийгмийн харилцан үйлчлэлээр дамжуулж төлөвшин хөгжиж байдгаар тайлбарладаг. Гэр бүл нь нийгмийн дүрэм журам, үнэт зүйлсэд сургадаг орчин гэдгийг онцолж гэр бүл доторх үзэгдэлд гол анхаарлаа хандуулдаг. Онолыг дэвшүүлэн тавьсан судлаач Бургес (E.Burgess 1886-1966) гэр бүл нь хууль эрх зүй зэрэг албан шинжтэй ойлголт бус харин тухайн гэр бүлийн гишүүдийн харилцан үйлчлэл дээр оршин тогтнож байдгийг онцолжээ. Мөн онолын үзэл баримтлалыг гаргасан судлаач Хилл (R.Hill 1912-1985) судалгаандаа үүргийг онцлоод үүрэг нь тухайн гэр бүлийн гишүүдийн хүсэн хүлээж буй хандлагаар тодорхойлогддог. Гэр бүл уг үүргээ тохирох хэмжээнд хэрэгжүүлж байвал гэр бүл тогтвортой, амар тайван байх бол эсрэгээр үүрэг өөрчлөгдөх, засан зохицох хэрэгцээ шаардлага гарах үед гэр бүл хямралд ордог байна. Гэр бүлээ цуцлуулж буй иргэдийн хувьд гэр бүл, үр хүүхдэдээ хүлээх үүрэг, хариуцлагаа биелүүлээгүй учраас тухайн нөхцөл байдлыг үүсгэсэн байна.

Солилцооны онол нийгмийн шинж чанараар тайлбарлахдаа “Хоёр хүний хооронд үүсэж буй солилцооны үйлдэл” гэж тодорхойлоод хүмүүс хоорондын харилцаандаа өөрийн ашиг мөн зарлагыг тасралтгүй солилцож нийгмийн харилцааг хадгалдаг болохыг тодотгодог. Солилцооны онолоор адил тэгш байр суурь нь тухайн солилцоот харилцааг хадгалах ба хуваарилалт дахь шударга байдал алдагдахад зөрчил, асуудлыг үүсгэдэг. Энэ нь гэр бүл дотор ч мөн адил хэлбэрээр илэрч гэр бүлийн гишүүд хоорондын зөрчил асуудлыг бий болгодог талаас нь хардаг байна. Гэр бүлийн хоорондын зөрчил маргаан бие биетэйгээ ойлголцохгүй байдал нь дахин гэрлэлтийг бий болгож байна. Энэхүү онол нь залуу хосуудын харилцаа харилцан үүрэг хүлээж, бэрхшээлийг давах итгэл найдвар дээр суурилсан солилцоонд үндэслэн явагддаг учраас хамгийн эмзэг байдаг хэмээн тайлбарладаг. Иймээс хамтын амьдралын эхний 5 жил хамгийн хямралтай байдаг бөгөөд харилцан солилцоо үр ашгийг авчрахгүй бол аюултай гэж тайлбарладаг.

Зөрчилдөөний онолын үндсээр гэр бүлийг хамгийн нэгдмэл нийгмийн нэгж гэсэн хандлагаар бус харин бусад бүлгүүдийн адилаар зөрчилдөөнийг бий болгодог бүтэц онцлогтой шинжээр нь тайлбарладаг. Онолоор нийгмийн мөн чанарыг зөрчилдөөн,

⁹ Гэр бүлийн хөгжлийн асуудал. Намжил,Т. Энхтүвшин, Ц. (2016)Уб,31-р тал

тэмцлээр тайлбарлаж үүний шалтгааныг хөрөнгөтний үзэл бүхий нийгмийн онцлог гэж үзээд гэр бүл нь уг нийгмийн давхаргын тэгш бус байдлыг нөхөн үйлдвэрлэдэг гол тогтолцоо болохыг онцолдог. Зөрчилдөөний онолыг үндэслэгч болох Маркс, Симмел (Marx & Simmel) нар Марксизмын үзэл баримтлалаар гэр бүлийг нийгмийн давхаргын тэгш бус байдлыг бий болгогч, нөхөн үйлдвэрлэгчээр хардаг байна.

Хүний насны ангилал тэр дундаа залуу насны хүн гэсэн тодорхойлолтыг шинжлэх ухааны хувьд тухайн бүлэгт хамаарах хүний биологи физиологийн онцлог, нийгэмд эзлэх байр суурь, нийгэмшилт, амьдралын түвшин, үзэл бодлын төлөвшилт, сэтгэлзүйн төлөв байдал зэргээс хамаарч харилцан адилгүй тогтоож тодорхойлсон байна.

Нийгмийн шинжлэх ухаанд ерөнхийдөө тухайн хүний нийгэмд эзлэх байр суурь эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагын чадвар бий болсон эсэх, нийгэмшил, эд хөрөнгө, албан тушаал г.м шалгуураар хүний насны ангилалыг тодорхойлон гаргадаг.

Гэвч хүн нийгмийн амьтан болохын зэрэгцээ оюун ухаан (сэтгэлийн), мах, цусан тогтоц бүхий биологийн төрөл зүйл мөн учир бие, сэтгэхүйн хөгжлийг шалгуур болгон авч үзэх нь зүйтэй. Тодруулбал, нийгмийн ухааны үүднээс хүний насыг ангилахдаа бие бялдар, сэтгэхүйн хөгжил, нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрөгдөх үе буюу бие даан эрх эдэлж, үүрэг хүлээх чадвар гэсэн хүчин зүйлсийн гурвалсан давхцлаар тодорхойлдог байна¹⁰.

Залуу насны тодорхойлолтыг дээрхи зарчимд тулгуурлан гаргах нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь залуу хүн бие физиологийн хувьд боловсорч гүйцэх, нийгмийн харилцаанд суралцаж, бие даасан эрх үүрэгтэйгээр оролцож эхлэх боловч оюун сэтгэхүйн хувьд бүрэн төлөвшөөгүй байх нарийн зааг үе шатанд байдаг.

Гэхдээ залуу насны ангилалыг гаргахдаа түүнийг хүүхэд нас болон насанд хүрсэн хүнээс ялган салгаж ойлгох нь нэн чухал бөгөөд залуу насны доод, дээд хязгаар болох шилжилтийн үеийн өсвөр нас, насанд хүрэх шилжилтийн үеийн насыг тодорхойлоход судлаачдын дунд нэлээд зөрүүтэй санал дүгнэлтүүд байдаг байна.

Судлаач Д.Цогзолмаагийн (*ШУТИС-ийн сэтгэл судлалын багш*) судалгааны ажлаас үзэхэд монголчуудын уламжлалт ойлголтоор насны ангилалыг дараахь байдлаар тодорхойлсон байна.

1. нялх үе /0-3/
2. балчир нас /3-7/
3. бага нас /8-12/
4. өөлийхүү буюу өсвөр нас /13-17/

¹⁰ [йЦр://Ы12пеГ№огк.шп/пеГ№огк/1ор1с/8Йо^/8949/пае/1](http://Ы12пеГ№огк.шп/пеГ№огк/1ор1с/8Йо^/8949/пае/1) - Залуу насны ангилалын талаарх бэсрэг шинжилгээ

5. орь залуу нас /18-25/
6. залуу нас/25-35/
7. идэр нас /35-45/
8. хижээл нас /45-60/
9. өтөл нас /60-80/
10. өндөр нас /80-аас дээш/

Энэхүү ангиллаар өсвөр наснаас залуу нас хүртэлхи буюу 13-35 насны хүмүүсийг одоо цагийн залуу хүн гэсэн ангилалд хамааруулж үзэж болохоор байна.

Монгол хэлний тайлбар тольд¹¹ орь насанд 18-25, залуу насанд 25-35 насны хүмүүсийг багтаан оруулсан нь дээрхи судалгааны ангилалтай давхцаж байна.

Монгол улсын эрхзүйн баримт бичгүүдэд залуу насны ангиллыг тодорхойлоход хамаарах дараахь томъёоллууд байдаг. Тухайлбал:

- Монгол Улсын Үндсэн хуульд иргэний сонгох эрхийг 18 наснаас эхлэн эдэлж төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй гэж заасан байна.
- Монгол улсын Иргэний бүртгэлийн тухай хуульд тус улсын иргэн мөн болохыг батлан гэрчлэх иргэний үнэмлэхийг 16 нас хүрсэн иргэнд шинээр олгоно гэж заасан.
- Иргэний хуульд 18-аас дээш насны хүнийг өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвартай насанд хүрсэн буюу иргэний эрхзүйн бүрэн чадамжтай гэж үзсэн байна¹². Мөн 16-18 хүртэлх насны иргэнийг, түүний хүсэлт, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцож болно гэжээ. 16-аас 18 хүртэлх насны иргэн хоршооны гишүүн байж болно. Харин насанд хүрээгүй буюу 14-18 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай байна гэж заасан. Бүрэн бус чадамжтай гэдэг нь өөрийн хөдөлмөрийн хөлс, оюутны тэтгэлэг, тэдгээртэй адилтгах бусад орлого, тэдэнд өөрийн үзэмжээр захиран зарцуулахад нь зориулж шилжүүлсэн эд хөрөнгийг захиран зарцуулах, энэхүү орлогыг банк, зээлийн байгууллагад хадгалуулах, өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх ахуйн чанартай хэлцэл хийх эрхтэй гэж заажээ.
- Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд асран хамгаалуулж байгаа хүүхэд 14 нас хүрмэгц асран хамгаалагч нь харгалзан дэмжигчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Тэтгүүлэгч хүүхэд 18 нас хүрсэн тохиолдолд тэжээн тэтгүүлэх эрх нь дуусгавар болно гэж туссан байна.

¹¹ Я.Цэвэл. Монгол хэлний тайлбар толь

¹² Монгол Улсын Иргэний хуулийн 14-15-р зүйл

- Монгол Улсын Эрүүгийн хуульд “Эрүүгийн хуулиар тогтоосон насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд хүрсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.” гэжээ. Харин 14-16 насны этгээд Эрүүгийн хуулийн тусгай ангийн заалтууд болох хүнийг санаатай алах, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах, хүчиндэх, бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар танхайрах зэрэг зүйл заалтад заасан хүнд болон онц хүнд хэргийг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байна.
- Хөдөлмөрийн тухай хуульд насанд хүрсэн буюу 18 наснаас дээш насны иргэний хөдөлмөрийн харилцааг тусгасан бөгөөд 14-18 насны иргэнийг хөдөлмөрийн харилцаанд түүнд тохирсон эрх, үүрэгтэйгээр оролцохоор заажээ. Тухайлбал, долоо хоногийн ажлын үндсэн цаг нь 18-аас дээш насны иргэний хувьд 40 хүртэл цаг байхаар заасан бол 14-15 насны ажилтанд 30 цаг хүртэл, 16-17 насны ажилтанд 36 цаг хүртэл байна гэж заасан байна. Үүнээс үзэхэд 14 нас хүрсэн Монгол улсын иргэн хөдөлмөрлөх ажиллах эрхээр хангагдаж энэ төрлийн эрхзүйн харилцаанд орохыг хуулиар зөвшөөрч байна.
- Монгол Улсын Даатгалын тухай хуульд зааснаар 0-16 насны хүүхдийн эрүүл мэндийн даатгалыг улсаас даахаар заасан ба түүнээс дээш насны хүмүүс ажил хөдөлмөр эрхлэлтээс олсон орлогоосоо албан болон сайн дурын даатгалыг төлөхөөр тусгагджээ.
- Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах хуульд 0-18 насны хүмүүст тус хуулийн үйлчлэл хамаарахаар заажээ. Гэвч хууль эрхзүйн баримтуудын хоорондын ойлголт, томъёоллын зөрүүг арилгах үүднээс энэхүү хуулийг Хүүхэд, өсвөр насны залуучуудын эрхийг хамгаалах хууль болгох эсвэл 0-14 насны хүүхдийн эрхийг хамгаалахаар заах нь зүйтэй санагдана.
- МУ-ын Үндэсний статистикийн хорооноос 2000 онд олон улсын стандартын дагуу гаргасан амьдралын мөчлөгөөр бүлэглэсэн ангилалд 15-24, 25-34 насны бүлэглэлийг багтаасан байна. Харин 2010 онд НХХЯ-аас гаргасан “Хүн ам нийгмийн хамгаалал хөдөлмөрийн үзүүлэлт”-д хүн амын бүлгийг 0-14, 15-59, 60 дээш насны гэж авч үзсэн байна. Энэхүү статистик баримтанд хөдөлмөрийн насны хүн ам, ажиллах хүчний судалгаанд 16-59 насны эрэгтэйчүүд, 16-54 насны эмэгтэйчүүдийг авч үзсэн бөгөөд АНУ, Англид манай улстай адил 16 наснаас эхлэн, харин Япон, Герман, Итали,

Франц зэрэг улсуудад 15 наснаас эхлэн тус судалгаанд хамруулан авч үздэг байна¹³.

Дээрхи Монгол Улсын холбогдох хуулийн баримт бичгээс үзэхэд иргэн хүнийг 14-16 наснаас эхлэн бүрэн болон бүрэн бус чадамж, эрхтэйгээр эрхзүйн харилцаанд орж болохыг тодорхойлон заасан байна.

НҮБ-ын бодлогын баримт бичгүүдэд ¹⁴ туссанаар залуучуудын стандарт тодорхойлолтонд 15-24 хүртэлх насны хүмүүсийг багтаасан байдаг. Гэвч дэлхийн улс орнуудын хүүхэд залуучуудын талаархи тодорхойлолтууд насны хувьд харилцан адилгүй буюу 7-39 насны хооронд байна. Жишээлбэл, Угандад 12-30 насны хүмүүсийг, Нигери, Бангладешид 18-35 насны хүмүүсийг залуучууд гэсэн тодорхойлолтонд багтаасан байна. Ерөнхийдөө залуучуудыг тодорхойлохдоо амьдралын мөчлөгийн хувьд нас биед хүрэх хүртэлхи хугацаа, тухайлбал сургууль төгсөх дундаж нас, насанд хүрсэн хүний нийгэмд үүрэг гүйцэтгэж эхлэх дундаж нас зэрэг хүчин зүйлсийг харгалзан авч үздэг байна.

Европын холбооны “Залуучуудын хөтөлбөр”-т¹⁵ залуу насны ангилалд 15-28 (зарим тохиолдолд 13-30) насны хүмүүсийг багтаан хамруулжээ.

Манай улсын “Өсвөр үе залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-т өсвөр болон залуу насны ангилалд хамаарах насны бүлгийг тодорхойлоогүй боловч хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ нь 10-35 насныханд чиглэсэн үйл ажиллагааг багтаасан байв.

Манай улсад идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг намуудын дэргэдэх залуучуудын байгууллагууд болон томоохон залуучуудын төрийн бус байгууллагуудын гишүүнчлэлийн насны дээд хязгаар нь гол төлөв 35 нас байна.

Эдгээрээс үзэхэд залуу насны ангилалд багтаж болох хүмүүс 15-35 насны хооронд хэлбэлзэж байна.

Үүнээс үндэслэн залуучуудын насны доод хязгаарыг 15, дээд хязгаарыг 35 нас гэж үзэж болох юм. Учир нь, залуу насны доод хязгаар гэж үзэж болох 15 насанд энэ насныхан сэтгэхүйн болон биеийн хөгжил, нийгэмшилтийн хувьд бусдад хүлээн зөвшөөрөгдөж, аливаад бие даан оролцох, хувийн байр суурьнаас хандах чадвар эзэмшин, хариуцлага хүлээх, биеийн хүчний хувьд ачаалал даах чадвартай болохын зэрэгцээ эрх зүйн чадамж бүрддэг. Харин залуу насны дээд хязгаарын тухайд сэтгэхүйн хөгжил тогтворжих, нийгмийн харилцааны туршлага, нийгэмд эзлэх байр суурь харьцангуй төлөвших, үхэл

¹³ НХХЯ - Хүн ам, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн үзүүлэлтүүд, 2010 он.

¹⁴ ОУХБ, НХХЯ - Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаархи ОУХБ-аас гаргасан баримт бичгийн эмхэтгэл 2006 он, 48 нүүр

¹⁵ [Н11р://ec.europa.eu/youth/youth11n/youth11n-1n-action-programme/cloc74 en.lt](http://ec.europa.eu/youth/youth11n/youth11n-1n-action-programme/cloc74 en.lt)

хагацал, төрөлт, гэрлэлт зэрэг хүн ам зүйн үзүүлэлтийн хувьд бусад насныхантай харьцуулахад өсөх үе тул залуучуудын насны дээд хязгаарыг 30-35 насны хооронд байна гэж үзэж болно. Энэ нь манай нийгмийн янз бүрийн бүлгийн хүлээн зөвшөөрч бий болгосон ойлголттой ерөнхий байдлаараа давхцаж байгаа юм.

Залуу насны ерөнхий ангиллын зэрэгцээ түүний дотоод ангилалд хамаарах өсвөр нас, орь залуу нас, залуу насны ангилалын заагийг гаргах нь хөндөх ёстой асуудлын нэг юм.

Судлаачид гэр бүлийн амьдарлын үйл явцыг үечлэн авч үзэх нь гэр бүлийн судалгааны нэг чухал тал гэж үздэг бөгөөд судалгааны зорилгоосоо хамааран үечлэлийг өөр өөрөөр томъёолсон төдийгүй ангилсан аргачлал нь өөр өөр байдаг. Тухайлбал социологит гэрлэсэн цагаас амьдарлын Гэр бүл нь зөрчилдөөний шалтгаан болохын хувьд ч зөрчилдөөний менежмент, зөрчилдөөний дүрэм журмыг зохицуулах механизмыг ч тайлбарладаг тул гэр бүл нь хоёрдмол шинжийг агуулдаг гэж үздэг. сүүлчийн мөч хүртэлх хугацааг хамаарсан нь амьдарлын үйл явцыг амьдарлын мөчлөг хэмээн томъёолдог.

Гэр бүлийн насны үечлэлээр харахад:

Английн социологич Ж.Бернард, Л.Томпсон нар гэр бүлийн амьдралын мөчлөгийг ангилахдаа гэр бүлийн амьдралын үргэжлэх хугацаа, эрчим, агуулгыг үндэс болгожээ. Тухайлбал, хүүхэдгүй залуу гэр бүл ойролцоогоор 2 жил, хүүхэд төрүүлж асрах хугацаа ойролцоогоор 2.5 жил, сургуулийн өмнө насны (6 хүртэлх насны) хүүхэдтэй гэр бүл ойролцоогоор 3.5 жил, сургуулийн насны (6-аас 13 насны) хүүхэдтэй гэр бүл ойролцоогоор 7 жил, шилжилтийн өсвөр насны хүүхэдтэй (13-20 насны) гэр бүл ойролцоогоор 7 ажил, хүүхэд өрх тусгаарлах үе ойролцоогоор 6.5 жил, бүх хүүхдүүд өрх тусгаарлах тэтгэвэрт гарах хүртэлх үе ойролцоогоор 13.5 жил, өндөр насны гэр бүл 16 ба түүнээс дээш жил үргэлжилнэ. Хамгийн эрчимтэй, ачаалалтай үе нь хоёр ба гуравдугаар үе бөгөөд энэ үед эцэг эх үр хүүхдээ асран халамжилж ачаалал ихтэй байна.

Оросын эрдэмтэн И.А Герасимова гэр бүлийн мөчлөгийг

- Гэр бүл үүсэхээс эхлэн отгон хүүхэд төрөх үе хүртэлх үе
- Отгон хүүхэд төрсөнөөс хүүхэд өрх тусгаарлах хүртэлх үе
- Бүх хүүхэд өрх тусгаарлах үе
- Эхнэр нөхрийн аль аль нь нас барах үе гэж 4 ангилаад үр хүүхэдгүй байх, хүүхдийн эндэгдэл, салалт, эсвэл нас баралт, холимог гэр бүлийн бүтэц

зэргээс хамаарч гэр бүлийн хөгжлийн жам ёсны үйл явц зөрчигдөж болно
¹⁶гэж үзсэн байна.

Харин доктор Н.Хавх гэр бүлийн амьдралын үйл яву үечлэхдээ арга билгийн онолын үүднээс эхнийх буюу доод нэгдэлийн үе /хоёр биеийг холбогч, сэтгэл санааны нэгдэл/ тэмцэлийн шат/ энэ үеэс амьдралын зөрчил бий болно/, дээд нэгдэлийн шат /эмээ болох үе/ гэж 3 ангилан үзсэн¹⁷.

Мөн Оросын эрдэмтэн В.А.Сысенка гэр бүлийн насны ангилалыг дараах байдлаар гаргаж ирсэн байдаг. Үүнд: Шинэ залуу гэр бүл 0-4 жил амьдарч буй гэр бүл, залуу гэр бүл буюу 5-10 жил, дунд насны гэр бүл 11-19 жил, тогтворгүй гэр бүл буюу 20 буюу түүнээс дээш жил хэмээн ангилсан байдаг.

Гэр бүлийн хосуудын нас 30 хүрээгүй, хамтын амьдрал нь 5 жилээс хэтрээгүй, хосууд хоёулаа анхны удаа гэрлэсэн гэр бүлийг залуу гэр бүлд тооцож, 18-21 насандаа гэрлэсэн залуучуудыг *түрүү залуу*, 22-30 насандаа гэрлэсэн залуучуудыг *дунд залуу*, 26-30 насандаа гэрлэсэн залуучуудыг *төгс залуу* гэр бүл бологсод гэж тодорхойлсон байдаг¹⁸.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т 18-31 насыг залуу хэмээн авч үзсэн байдаг. Харин залуу гэр бүл гэсэн насны зааг нь “эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай” хуулийн 3.1.4-т залуу гэр бүл гэж нөхөр, эхнэрийн аль аль нь 35 хүртэлх насны гэрлэгчдийг хэлнэ хэмээн заасан байдаг¹⁹.

Гэр бүлийн амьдралын үйл явцын үечлэлийг амьдарлын эхний жилүүд, амьдралын дунд үе, тогтсон амьдрал гэж үечлэж болох юм. Судалгаанаас үзэхэд салалт амьдралын эхний болон дунд үед нилээд хэмжээгээр байдаг байна. Амьдралын эхний үед бие биенийхээ алдаа дутагдалыг олж харахгүй хайр сэтгэлээр явж байдаг, дунд үед гэр бүлийн амьдралаас гадна нийгмийн олон талт харилцаанд орох, амьдралын нөхцөл, гэр бүлийн гишүүдийн үзэл бодол, сонирхол өөрчлөгдөж, гадны нөлөөлөл ихсэх болон өдөр тутмын амьдралын олон асуудлаас маргалдах, зөрөх байдал ихэсдэг.

Залуу гэр бүл дараах үе шатыг дамждаг.

Гэрлэх ба хараахан хүүхэдтэй болоогүй үе. Энэ үе шатанд гэрлэгсдэд гадаад ба дотоод хил хязгаар бий болж, тэдний нийгэмд эзлэх байр суурь өөрчлөгдөнө. Тэд хэн

¹⁶ Меньшутин М.П “Залуу гэр бүлд тусламж” УБ, 1990, 95-р тал

¹⁷ Хавх. Н “Эр хүнд оюун санааны, эм хүнд сэтгэлийн баялагийг байгаль илүү заяажээ” УБ, 1994, 3 тал

¹⁸ Мандах З. “Орчин үеийн гэр бүлийн харилцааны зарим асуудал” 2010

¹⁹ “Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай” хууль, 2006

нэгнийхээн эцэг эхтэй хамт байх уу?, тусдаа амьдрах уу? гэдгээ шийдэх хэрэгтэй болно. Тэдэнд нийгэм, сэтгэл хөдлөл, бэлгийн харилцаа болон бусад асуудлууд гарч ирнэ. Гэрлэгсдэд өөрсдийн нийгмийн үүргийг ухаарч, өдөр тутмын ахуй амьдралаа зохион байгуулахтай холбогдон сэтгэл зүйн асуудал илэрч, мэдрэмж өөрчлөгдөх болно. Гэр бүлийн нийгмийн ямар давхаргад хамаарах, мөнгө санхүүгийн асуудлыг хэрхэн захиран зарцуулах зэрэг хэрэгцээгээ хангах асуудлыг шийднэ. Хосуудын хоорондын харилцаанд хүсэл сонирхол, хүмүүжлийн хоорондын ялгаа илэрдэг. Энэ үе шатанд хосууд анхны хүүхдээ төрүүлэх болон цаашдаа хэдэн хүүхэдтэй болох тухайгаа ярилцах нь чухал.

Энэ шатанд тэдний үүргийн хуваарь тодорхойлогдоно. Бие биенийхээ эцэг эхтэй харилцаа холбоонд орж, амьдралын шинэ нөхцөлд дасан зохицох хэрэгтэй болно. Гэрлэсэн хосууд заримдаа нэг хэсэгтээ хүүхэд төрүүлэхийг хүсэхгүй бөгөөд хүүхэд өсгөх бэлтгэлгүй байх явдал гардаг. Түүнээс гадна энэ шатанд хосууд амьдралын хүнд хэцүүг мэдэрч эхэлснээр тэднийг сорих шалгуур гарч ирнэ. Энэ үе шатны гэр бүлд хүүхэд мэндэлснээр хэн хүүхдээ өсгөх бойжуулах тухай асуудал тавигдана. Өөрөөр хэлбэл хосууд шинэ үүрэг хариуцлага хүлээсэн эцэг болж, харин тэдний ээж аав нь эмээ эмээ өвөө болно. Хүүхэд асарч бойжуулахтай холбоотой магадгүй гуравдагч хүнийг байлгах уу зэрэг олон нарийн асуудал гарч ирнэ. Жишээ нь: Ихэнхдээ эхнэр гэртээ хүүхэд асарч, харин нөхөр нийгэмд ажиллах ар гэрээ тэжээх үүрэг хүлээдэг. Үүнтэй холбоотой эмэгтэй хүн гэрийн ажилд дарагдах, үүний улмаас бухимдах, санаа сэтгэлийн элдэв хямралд орох үзэгдэл илэрч болно. Зарим үед хүүхдээ өсгөж, халамжлахад туслахыг шаардсанаар эрэгтэй хүн албан ажил дээрээ өсөх гэсэн хүсэлд нь эхнэр хүүхэд саад болж буй мэдрэмж төрөх нь бий.²⁰

Гэр бүлийн эдийн засаг, аж ахуйг хөтлөн зохион байгуулах нь

Залуу хосуудад тохиолддог амьдарлын анхны хариуцлагатай үеийн нэг бол гэр бүлийн аж ахуйн асуудал юм. Гэр бүлийн аз жаргал нь ихэнхдээ хайр дурлал, чин сэтгэлийн харилцаа юм. Мөн амьдралын өдөр тутмын асуудлаас шалтгаалдаг гэж үздэг. Харамсалтай нь өдөр тутмын аар саар зүйлд гэр бүлийн харилцаанд даашгүй саад болж, зөрчилд хүрэх нь олонтой.

Залуу гэр бүлд үүсдэг зарим онцлог хямрал асуудлыг тэд амжилттай даван туулах нь цаашдын засан зохицох үед нөлөөлдөг. Үүнээс дурдвал: залуу хосууд бие биенээ гадна байдлыг нь танин мэдэж амждаг боловч гэрлэлтээр тэд бие биенийхээ дотоод орчинг мэдэх боломжтой сэтгэл зүйн занганд ордог гэж үзэж болно. Эхний үед бал сар байдаг тул бүх

²⁰ Меньшутин М.П “Залуу гэр бүлд тусламж” УБ, 1990, 19-р тал

зүйл маш сайхан байснаа аажимдаа энэ байдал буурч хооронд нь зай үүсч байгааг ажиглаж эхэлдэг. Эхний хямрал магадгүй гэрлээд эхний долоо хоногт гэр бүл салалтаар дуусч болох талтай, энэ нь гэнэт том нууц илэрсэнтэй холбоотой маш богино хугацаанд гэрлэлт нь салалт болдог. Гэхдээ энэ тохиолдол маш цөөн хувь байдаг.

Дараагийн тохиолддог асуудал нь гэрлэлтийг нь эцэг эх нь хүлээн зөвшөөрөхгүй амжилтгүй гэрлэлт болсон гэж үздэг явдал юм. Хадмын талдаа хүлээн зөвшөөрөгдөх нь нилээдгүй зөрчил маргааны үндэс болдог байна. Нөгөө талдаа тэд хүлээн зөвшөөрсөн боловч дөнгөж гэрлэсэн хосууд нь эцэг эхээсээ хамааралтай байдал хэвээр санхүү болон сэтгэл зүйн харилцааны хамаарал нь зөрчилдөөний эх үндэс болдог.

Хосууд тусламж авахыг хүсдэг боловч нөгөө талдаа тэдний амьдралд оролцуулахгүй байх хүсэл давамгайлдаг гэж хэлж болно. Энэ нь шинэ гэр бүлд материаллаг ба сэтгэл зүй бие даасан байдал үүсэх, хариуцлагатай болон хөгжих тусгаар тогтнох байдал, насанд хүрэх зэрэг олон чадваруудыг бий болгох үндэс байдаг.

Залуу хосуудын хувьд бие даан шийдвэр гаргах нь бэрхшээлтэй төдийгүй тэдний харилцаанд асуудал үүсгэдэг. Учир нь энэ үед хоёр тал эго төвтэй буюу би төвтэй бодол давамгай байдлаас болдог байна.

Гэр бүлд шинэ иргэн мэндэлснээр гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага нэмэгддэг. Энэ байдал нь гэр бүл дэх харилцаанд зөрчил, стресс болдог байна. Шинэ амьдарлын хэв маягт дасах хэрэгтэй, сэтгэл санааны болон биений хүчний ачаалалууд нэмэгдэх /хүүхэд асрах, нойргүй хонох/ зэрэг нь стресс үүсэх хүчин зүйл болдог байна.

Ихэнх залуу гэр бүлийн нэг онцлог бол өөрийн гэсэн орон байргүй байх нь нийтлэг бэрхшээл байдаг. Иймд тэд эцэг эхийнхээ хамт амьдарч аж ажууг хамтран эрхэлдэг. Бусадтай хамт амьдарснаар хариуцлагын мэдрэмжээ алдахад хүрч болох учир тааламжгүй байдал гарвал хосуудын хэн нэг нь тустай амьдрах нь олонтой. Үүнийг үр дагавар гэр бүлээс гадуурх харилцаа гарч болно.

Хүүхэд төрөхөөс өмнө хосууд ижил эрх эдэлдэг бол хүүхэд төрснөөс хойш эхнэр зөвхөн хүүхдийнхээ төлөө санаа тавьж, найз нөхөд болон бусад хүмүүстэй харилцах харилцаа нь багасдаг бол, нөхрийн хувьд эдгээр харилцаанд өөрчлөлт ордоггүй, өмнөх байсантайгаа ижил байдаг. Энэ байдал нь эргээд гэр бүлийн харилцаанд хямрал, стресс болдог тул хосуудын харилцан ойлголцох ур чадвараас шалтгаалан энэ байдлыг өөрчлөх боломжтой.

Орчин үед гэр бүлийг бүтэц, хэв маяг, харилцааны олон талт онцлогоос нь хамааруулан дараах байдлаар ангилдаг²¹ байна.

Хосууд гэр бүл болохдоо насан туршдаа хамт амьдрах эрхэм зорилгыг асгуулдаг. Гэрлэсэн цагаас хойших гэр бүлийн амьдрал нь өөрийн гэсэн онцлогтой, тодорхой цаг хугацааны үргэлжлэл юм. Тиймээс хамт амьдарсан хугацаанд аз жаргалтай мөчүүд олон тохиолддог боловч янз бүрийн хүндрэлтэй асуудалтай нилээд тулгардаг. Амдарлын нөхцөл, эрүүл мэнд, хөгшид, хүүхдийн асуудал, ажил төрлийн байдал, сонирхол, үнэлэмж зэрэг наад захын энгийн зүйлээс төвөгтэй асуудал хүртэл амьдралд тохиолдох тур зуурын бэрхшээлээс болж бие биеэндээ бухимдлаа гаргах, шантрах, гутрах, зан ааш нь өөрчлөгдөх зэргээр гэр бүлийн харилцаанд сэв суух үзэгдэл гарах болжээ. Амьдарлын түр зуурын бэрхшээлийг зарим хүмүүс амьдралын зовлон гэж ойлгодог болохоос жам ёсны үзэгдэл нь амьдарлын үе шат бүрт өөр өөрөөр илэрдэг. Амьдарлын эхний үе шатанд залуу гэр бүлийн зарим гишүүд наад захын бэрхшээлийг даван гарах сэтгэлийн тэвчээр дутагддаг. Үүнээс болж бие биеэндээ бухимдах явдал үүсдэг. Бие хүн бүр өөрийн гэсэн онцлог зан чанар, үзэл бодолтойгоо мэдэх нь чухал.

Бие хүний үнэт зүйл хэрэгцээний бүтэц, түүний хөгжил хөдөлгөөнийг тодорхойлдог нийтлэг ойлголт бол харилцаа юм. Хүн хүрээлэн буй орчинтойгоо идэвхитэй, уялдаа холбоо тогтоох, мөн өөрийнхөө хэрэгцээгээ хангахын тулд янз бүрийн бэрхшээлийг даван туулах шаардлагатай болдош. Чухамдаа хэрэгцээг хангахад саад болж байгаа бэрхшээлүүд үйл ажиллагааг хөдөлгөгч хүч нь болж түүний үе шатыг тодорхойлдог. ²²Бэрхшээл нь үйл ажиллагаанд чухал шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Гэр бүлийн тогтвортой байдал, хувь хүмүүсийн амьдрал, сэтгэл санаанд төдийгүй, нийгмийн тогтвортой эерэг нөлөө үзүүлдгээрээ нийгмийн үнэт зүйл болж байдаг. Иймээс гэр бүлийн тогтвортой байдал түүний шинж чанар, нийгмийн ач холбогдлыг судлах, гэр бүлийн харилцаа алдагддаг шалтгаануудыг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх арга замуудыг хайхад судалгааны гол чиглэгдэх ёстой.

Английн эрдэмтэн Р.Уайтфилд, Америкийн эрдэмтэн А.Маслоу нар гэр бүлийн тогтвортой байдал болон онцлогийг судлахад эхнэр нөхөр хоёрын хэрэгцээ сонирхолын таарамжийг судлах нь чухал хангагдаж байгааг тодорхойлохдоо А.Маслоугийн бие физиологийн хэрэгцээ, аюулгүй байх хэрэгцээ, нийгмийн бүлэгт харьяалагдах хэрэгцээ, өөрийгөө хүндэтгэх хэрэгцээ, өөрийгөө хайрлах хэрэгцээ хангаснаар хангагддаг. Эдгээр

²¹ Гэр бүлийн боловсрол. Оюун-Эрдэнэ,Б.(2017) УБ, 47-р тал

²² Гэрлэлт гэр бүлийн философи, ёс зүйн зарим асуудал Тунгалаг. Д. УБ, 2010, 12-р тал

хэрэгцээнүүд шат дараалан хангагдсанаар гэр бүлийн тогтвортой байдал бий болох үндэс тавигддаг гэж үзсэн байна.

Судлаачид гэр бүлийн харилцааг бэрхшээлд хүргэдэг дараах хүчин зүйлсийг тодорхойлжээ. Үүнд:

- Гэр бүлийн харилцааг гишүүдийн хувийн онцлог зан араншин амьдарлын үнэт зүйлсийн баримжаалал
- Гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаа тэдгээрийн нягтрал, харилцан ойлголцлын түвшин
- Гэр бүлийн амьдарлын зарчим, тодорхой нөхцөл байдал
- Гэр бүлийн доторхи зөрчилтэй байдал

Жон Павел гэр бүлийн харилцааны талаарх номондоо харилцааны үе шат:

Тав дах үе шат: Энгийн сэдэв-ийм харилцан яриа аюул багатай байдаг. Бид энгийн сэдвээр ярилцахдаа.

Дөрөв дэх үе шат: Бусдын тараарх баримтыг тайлагнах. Энэ үед бид 6 цагийн мэдээгээр гарсан мэдээлэл, хов жив, бусад сэдвийн сэдвүүдээр ярилцдаг боловч эхнэр нөхрийн санаа бодлоор ярилцдаггүй.

Гурав дах үе шат: Санаа бодол болон шүүмжлэл. Энэхүү үеэс эхлэн хүмүүс жинхнээсээ харилцаж эхэлдэг. Харилцаж аажмаар цухуйж өөрийн бодол санаа, шийдвэрүүлээс хуваалцдаг. Өөрийн хэлсэн үгсийг хүлээн зөвшөөрөхгүй байгааг мэдсэн үедээ хэлэх үгээ нөөцөлж эхэлдэг. Энэ бүгдээс гадна гэр бүлийн амьдралд тохиолддог хамгийн гол онцлог бэрхшээлүүд нь:

- Насны онцлог
- Нийгмийн нөлөө
- Оюун санааны хэмжүүр
- Үндэс угсааны ялгаа
- Санхүүгийн чадавхи зэрэг юм.

Насны онцлог: Хайр сэтгэлд хамгаагүй гэж ярьдаг. Гэвч бодит байдал дээр насны ялгаа их гардаг. Иймд хэрэв та нас хол зөрүүтэй хүнтэй гэр бүл болсон амьдрал чинь бодож байснаас чинь тэр тэс өөр байж магадгүй тул бэлтгэлтэй байх нь чухал юм.

Оюун санааны хэмжүүр: Өөрийгөө хэт доогуур үнэлэх нь гэр бүлийн амьдралын тэнцвэрийг алдуулдаг. Айр гэрийн эр хүн илүү ухаантай байж, гэр бүлээ бүрэн бүтэн, эв найртай, элбэг дэлбэг, хангалуун авч явах ёстой. Харин эмэгтэй нь гэр бүлээ халамжлан тэтгэгч, хайр энэрэлээр гийгүүлэгч аврагч байх хэрэгтэй.

Үндэс угсааны ялгаа: Хэдийгээр бид чөлөөт ертөнцөд амьдарч байгаа ч үндэс угсааны асуудал хамгийн ярвигтай тооцогддог. Зан заншил уламжлал ахуйгаас эхлээд үндэстэн угсаатны хооронд ялгаа их. Иймд гэр бүл болохдоо үндэс угсаа ёс журам, хэл соёл, ахуйн онцлог зэргийг харгалзах нь чухал. Өөр үндэс угсааны хүмүүс гэрлэхэд сэтгэл зүйн бэрхшээл л хамгийн хэцүү байдаг.

Санхүүгийн чадавхи: Амьдрал дээр гэр бүлийн санхүү, арын ажлыг гол төлөв эмэгтэйчүүд зохицуулдаг нь тодорхой асуудал билээ. Учир нь тэд нарийн ширийн зүйл зохицуулах чадвар сайтай. Айл гэрийн санхүүгийн хувьд хэнээс ч хараад бус байх нь чухал. Үүнд эрх хүний төрөлхийн авъяас чадвар, овсгоо самбаа, бас ноён нуруу л гол үүрэгтэй байдаг байна. Энэ бүх бэрхшээл нь Монголын одоогийн нийгэмд улам их ажиглагдаж байна. Мөн гэр бүл дэх харилцаанд нийгмийн зүгээс сөргөөр нөлөөлж буй асуудлууд ч байна. Нийгэм дэх эмх замбраагү байдал хүмүүсийн сэтгэл зүйн таагүй байдалд оруулж байна.

- Эдийн засгийн хямрал
- Амьдарлын түвшин хэт ялгаатай байдал
- Материаллаг хангамж
- Гэр бүлийн асуудлаар мэдлэг хомс
- Ажилгүйдэл архидалт

Гэр бүлийн амьдралд тохиолддог хямрал хэд хэдэн үе шаттай бөгөөд энэ нь ихэвчлэн залуу хосуудад тулгамдаж байна.

Эхний үе нь гэр бүл болсноос хойших 3-7 жилийн хооронд үргэлжилдэг. Энэ нь өөр орчинд өссөн, өөр өөр зан ааштай хүмүүсийн харилцан бие биедээ дасан зохицох хүрэлцэх хугацаа юм. Эхнэр нөхөр үүрэг хариуцлага ухамсарлах хугацаа нь энэ үед хамаарагдана. Гэр бүл болоход хосуудын үзэл бодол, ёс суртахуун, хүсэл сонирхол, зан төлөв, секс зэрэг нь зохих хувиар нөлөөлдөг. Жишээ нь: гэр бүл болох болж байгаа хосууд яг ижил зантай бол дасан зохицоход хэцүү харин хурц ааш зантай бол бие биетэйгээ байнга шөргөлдөж, харилцан буулт хийх сонирхолгүй байдаг. Гэр бүлийн байдал мушгиа байдлаар үргэлжилдэг. Энэхүү эргүүлэг анхандаа тун ч эрчимтэй, учир нь үл ойлгогдом байдлаар мушгиран олон маргаан үл ойлголцол бүр салалт хагацал тунирхлаар дүүрэн эргэлдэнэ. Эрдэмтэд судлаачдын олж мэдсэнээр гэр бүл салалтыг ихэнх нь эхний 5 жилийн дотор болдог байна.

Эхний жил: Эцэг эхийнхээ анхаарал халамжид бөмбөрч байсан залуу хүмүүс өөрийнхөөрөө бүхнийг хийх гэж өмнөө гэнэт тулгарсан ахуйн олон асуудлыг шийдвэрлэж чадахгүй тулгамддаг. Ингээд гэр бүлийн амьдарлын төлөө өөрийнхөө хараат бус байдал,

эрх чөлөөгөөр дэнчин тавихгүйн тулд асуудлыг шийдэх хамгийн хялбар арга болгож салалтыг сонгож авдаг.

3-дах жил: Энэ үед ихэнх гэр бүл хүүхэдтэй болж энэ залуу гэр бүлийн өмнө гинэ шалгуур болон гарч ирнэ. Хүүхэд гэдэг асар их анхаарал халамж, маш их хугацаа шаардана.

Ингээд олон бэрхшээл ар араасаа цувран гараад ирэх үеэс залуучууд харилцан тэвчээр халамж гаргахын оронд яг эсрэг зан чанар, үйлдэл гаргаж эхэлдэг.

5-дах жил: Харин тав дах жил дээрээс эхлэн хосуудын хоорондын үл ойлголцол маргаан нь голдуу гэр бүлийн эдийн засгийн байдал, нэгэнт биелэгдэхээ өнгөрч нөхөрсөн итгэл найдвар эд хөрөнгөний байдлаас үүдэлтэй байна. Эхнэр нь хоорондын таарч тохирохгүй байгаа байдлаа нөхрийнхөө арчаагүй, ядуу, мөнгө бага олдогтой холбон буруутгаж эхэлнэ. Энэ үед тохиолдох салалт нь голдуу удаан хугацаагаар хуримтлагдсан сэтгэл хангалуун бус байдлаас улбаатай байна.

7-8 дах жил: Гэрлэсний долоогоос найман жил бол ерөөсөө дэлхий дахины бүх л улс гүрэнд салалтын оргил үе гэж тооцогддог. Энэ нь ихэвчлэн дунджаар 30 нас хүрч буй хүний насны хямралтай тохиодог. Учир нь энэ үедээ хүн голдуу ажил, мэргэжилээ сольж, илүү ихэд тэмүүлж, оршин суух газраа ч өөрчилж, өөрөөр хэлбэл амьдарлаа бүхлээр нь өөрчилдөг байна. Яг энэ хямралд эрчүүд илүүтэй өртөмтгий байдаг. 30 нас бол эрчүүд жинхэнэ ид үе нь эхэлж насанд хүрч байгаа үе юм.

15 дах жил: Энэ үед гэр бүлийн хямралын өөр нэг оргил эхэлнэ. Ихэнх хүмүүст гэр бүлийн амьдрал гэдэг нэгэн хэвийн уйтгартай зүйл мэт бодогдох болсон байна. Эрэгтэй, эмэгтэй хэн нь залуу нас өнгөрч амьдрал жирэлцэн өнгөрч буйг ойлгоно. Гэр бүлийн зүгээс сэтгэл хөдөлгөсөн аз жаргал баяр баясгаланг мэдрүүлсэн үг, үйлдэл гаргах нь бараг үгүй болсон байна. Нас нь дунджаар 40 хүрнэ. 40 нас бол угаасаа гэр бүлээс гадуурх янаг амрагийн явдалын хамгийн идэвхтэй оргил үе гэж тооцогддог.

25-дах жил: Мөнгөн хуримын жил. Харамсалтай нь цөөнгүй удаа гайхамшигтай баяр баясгалан, уйтгар гуниг болон хувирдаг. Энэ үе бол хүн амьдралдаа юунд хүрч, амьдарлын ямар бааз, суурийг бий болгов гэдэгтээ дүгнэлт хийдэг. Ингээд бодоод дүгнээд үзтэл амьдрал нь ямар ч утга учиргүй юм шиг юунд ч хүрээгүй юм шиг санагдангуут сэтгэлээр унаж гэмтэнг гаднаас эрж хайхдаа хамгийн түрүүнд ханиа л буруутгаж эхэлдэг. Яг энэ хямралд эрчүүд илүүтэй өртөмтгий байдаг. 30 нас бол эрчүүд жинхэнэ ид үе нь эхэлж насанд хүрч байгаа юм.

Залуу хосууд бие биедээ хайр сэтгэлийн холбоотой байсан ч хамтын амьдралын явцад нийгмийн зүгээс ирэх боди хүндрэл бэрхшээлийг даван туулах сэтгэл зүйн болон материаллаг нөөцийг бүрдүүлэхэд анхаарах. Монголын олонх залуус гэр бүлээ

төлөвлөөгүй, гэр бүл зохиож хүүхэдтэй болно, өөрийн гэр оронгүй давхар гэр бүл үүсгэж байгаа байдал нь хүндрэл учруулж байна. Тиймээс гэр бүлийн боловсролын талаар мэдлэг мэдээлэл хангалттай сонсох хэрэгтэй.

Гэр бүлийн тогтвортой, зөв харилцаатай, хүний амар тайван аж төрж, хөгжих боловсрох суурь орчин болон хөгжүүлэхэд шаарлагатай мэдлэг, чадварын цогцыг гэр бүлийн боловсрол гэнэ. Гэр бүлийн боловсрол бол хүний насан туршдаа эзэмших боловсрол юм.

Залуу гэр бүлийг дэмжих тогтолцоо бол алжын байр, орлоготой байх явдал юм. Санхүүгийн хүндрэл бэрхшээлээс үүдэн гэр бүлд асуудал үүсэж, улмаар хүүхдээ тэжээн тэтгэж чадахагүйд хүрнэ. Мөн гэр бүлийн хүчирхийллээс үндсэн шалтгаан санхүүгийн хүндрэл болж байгааг сүүийн үеийн судалгаа харуулж байна.

Хүүхдийн хүмүүжил төлөвшилд эцэг эхийн зан харилцаа болон нийгмийн хандлага маш их нөлөө үзүүлж байна. Залуу ээжүүд гэртээ хүүхдээ харж өсгөн хүмүүжүүлэх шаардлага байдаг ч мөн санхүүгийн хүндрэлээс үүдэн хүүхдээ өөр хүнээр өсгүүлэх тохиолдол гарч байна. Энэ нь зөвхөн санхүүгийн бэрхшээлээс гарах гэсэн оролдлого боловч хүүхдийг хүчирхийлэлд өртөх боломжийг ихэсгэх, эрүүл мэнд, бие мах бодийг гэмтээх, хохироох нэгэн үндсэн шалтгаан болж байна.

Гэр бүл дотор ил тохиолддог бэрхшээл бол харилцааны бэрхшээл юм. Залуу гэр бүлийн амьдралын анхны алхмуудаас гэргий, нөхрийн харилцаа ямар байх ёстой талаар санал зөрөлдөөн гарч ирж болох юм. Хэрэв та харилцаагаа зузаатгахын хүсэж байгаа бол чин сэтгэлээсээ харилцах шаардлагатай болно. Бид бусдыг хүлээн зөвшөөрснөөр тухайн хүний хэлсэн үгийг нь хүлээн зөвшөөрч байна гэсэн үг биш. Өөрийн сэтгэгдлийг хуваалцаж байгаа хүний санаа бодлыг ойлгож ухаарна гэдэг бол тухайн хүнийг хүлээн зөвшөөрнө гэсэн үг. Энэ эхнэр нөхөр хоёр бол бие биенийгээ хүлээн зөвшөөрч эрүүл харилцааг бий болгох нь гэр бүлийг бат хадан суурин дээр барьж буй хэрэг юм.

Өнөөгийн нийгмийн гэр бүлийн байдлыг сөрөг талаас нь харвал гэр бүл салалт нь залуу гэр бүлийн дунд түгээмэл болсон. Шалтгаан нь нэг нэгэндээ итгэх итгэлгүй, хөндлөнгийн зарим нөлөөллөөс болж бие биенийгээ буруугаар ойлгох зэрэг бие биедээ итгэх итгэл нь алдрах, архи дарс, зугаа цэнгэлээс болж зайлшгүй буюу албан хүчээр /хүсээгүй жирэмслэлт, санамсаргүй зугаацах байдлаар үүсгэсэн бэлгийн харьцаа, төлөвлөөгүй гэр бүлийн асуудал гэх мэт болон сэтгэл хөдлөлөөр гэр бүл хэмээх эрхэм нандин бичил нийгмийг бүрдүүлэхдээ хайнга хандаж, төлөвлөгөөгүй гэрлэж байгаагаас уг асуудал дэлгэрч улам залуужих нэг шалтгаан болдог.

Залуу гэр бүл ба тэдний эцэг эхийн хоорондын харилцаа

Залуу гэр бүлийн сэтгэл зүйн уур амьсгал нь олон зүйлээс шалтгаалдаг. Хосууд эцэг эх, хадам-хүргэн, бэр-хадам мөн гэр бүл дэх насанд хүрэгчдийн хооронд тэдний харилцааны төлөв байдал бүрэлдэн байгаа нөхцөл байдалтай уялдан сэтгэл хөдлөл, материаллаг байдлын харилцан дэмжлэг үргэлжилсээр байдаг. Гэр бүлийн амьдралын чухал талуудын нэг нь эцэг эх хүүдхийн харилцан бие биедээ үзүүлэх харилцах туслалцаа хамаарал юм. Залуу гэр бүл, тэдний эцэг эхийн амьдралын шатлал нь дараах үе шатаар явагддаг байна.

1-р шат: Хүүхэд мэндлэх хүртлэх шинэ гэр бүл. Энэ үед залуу гэр бүл ахуйн ажлыг бие даан өөрсдөө шийдвэрлэхийг эрмэлздэг. Энэ эрмэлзлэлд гэр бүлийн амьдрал, түүнд хосууд хэр бэлтгэгдсэн, мөн тэдний нийгэм-сэтгэл зүйг хөгжлийн асуудал яригддаг. Хамтын амьдрал дасан зохицох явцад эдийн засгийн асуудлаа шийдэхийн зэрэгцээ тохиолдож болох бусад бэрхшээлийг даван туулах нь чухал.

2-р шат: Энэ шатанд залуу гэр бүлд анхны хүүхэд төрснөөр хосууд тэдний эцэг эхэд /ээж-аав, эмээ-өвөө/ шинэ үүрэг нэмэгдэнэ. Энд ахмад үеийнхэн ач зээгээ асарч, хүмүүжүүлэхэд тусалдаг.

3-р шат: Ахмад үеийнхэн /эмээ, өвөө/ гавьяаныхаа чөлөөнд гарсанаас ач зээгээ хүмүүжүүлэх нь эрчимжинэ. Гэвч энэ шатанд залуу гэр бүл олон асуудалтай тулгардаг.

4-р шат: Хөгшчүүдийн бие биедээ тавих анхаарал халамж дээшилж, ач зээ нь насанд хүрсэнээр гэрийн аж ахуйгаа үргэлжлүүлж, өөрөө үйлчлэх цаг зав чөлөөтэй болно.

5-р шат: Гэр бүл дэх бүлгүүдийн харилцаа хөгжинө. Эцэг эх өндөр настай болсоноор тэдэнд хүүхдүүд нь санаа тавьж, асарч хамгаалах сэтгэл санааны туслалцаа үзүүлэх хэрэгтэй болдог. Иймд эцэг эх хүүхдийн хоорондын харилцаа илүү ойртож бэхжинэ. Залуусын амьдралд тэдний эцэг эхийн үүрэг илэрхий багасахад тэд жинхэнэ ёсоор бие даан амьдрахад нөхцөл бүрдэнэ. Гэвч залуу гэр бүл зайлшгүй шийдвэл зохих асуудлууд гарч ирдэг.

Залуу гэр бүлийн дасан зохицол

Гэр бүлийн сэтгэл зүйн нэг чухал асуудал нь дасан зохицох тухай асуудал юм. Хамтын амьдралын дасан зохицохын сэтгэл зүйн мөн чанар яаж бүрдэх вэ? Сэтгэл зүйчдийн үзэж байгаагаар энэ нь харилцагчдийн зан үйл мэдрэмж, оюун санааг хүлээн зөвшөөрснөөр бий болно. Дасан зохицол нь гэр бүлийн харилцааны бүх хүрээгээр яригдах зүйл. Тодруулбал:

- Материаллаг ахуй
- Хувийн харилцаа

- Ёс суртахууны, сэтгэл зүй

Өөрөөр хэлбэл: Гэрлэгсдийн дасан зохицол нь ахуйтай төдийгүй сэтгэл хөдлөл ёс суртахуун- соёлын төвшинтэй холбоотой гүнзгий ойлголт юм.

Материаллаг ахуйн дасан зохицол нь: Гэр ахуйн ажлыг гүйцэтгэхэд гэрлэгсдийн эрх үүргийг зөвшөөрөхтэй холбоотой. Орон гэрийн тавлаг байдал ханамж, хөдөлмөр хуваарилалтандаа сэтгэл ханамжтай байх асуудал ордог.

Ёс суртахуун-Сэтгэлзүйн дасан зохицол нь: Хүний тогтсон хандлага оюун санааны үнэт зүйлийн чиг баримжаа сонирхол, үзэл бодол, ертөнцийг үзэх үзэл болон харилцаанд үндэслэгддэг. Хувийн харилцааны дасан зохицолд эхнэр нөхрийн бэлгийн харилцааны асуудал хамаарна.

Судлаачид дасан зохицол нь: Анхдагч ба хоёрдогч гэж байх бөгөөд анхдагч дасан зохицол нь сэтгэл зүйн хувьд үүргийн ба бие хүн хоорондын гэсэн төрөлтэй гэж үзжээ.

Анхдагч үүргийн дасан зохицлын шатанд гэр бүлийн харилцаа бүрэлдэн, гэрлэгсэд амьдралдаа мөрдлөг болгох ямар сэдэлтэй чиглэл байна вэ? Гэдэгт суралцах нь чухал. Энэ нь ялангуяа гэр бүлийн ахуй болон ёс суртахуун сэтгэл зүйн харилцаагаа баримжаалах боломжийг олгоно. Гэрлэгсэд харилцагчийнхаа тогтсон харилцааг хүлээн зөвшөөрч, гол сэдэл тэмүүллийг харгалзах нь чухал. Үүний дүнд хамтын амьдралын эхний шатанл гэр бүлийн үүргийг ухаалгаар зохицуулах боломжтой болно. Анхдагч дасан зохицолд анхаарах нэг чухал нь гэр бүлийн үүргийн хуваарилалт тухай төсөөллийг хүлээдэг зөвшөөрөх явдал юм.

Бие хүний хоорондын дасан зохицол нь:

- Сэтгэл хөдлөл
- Танин мэдэхүй
- Зан үйл гэсэн 3 бүрэлдэхүүнтэй байна.

Бие хүн хоорондын дасан зохицол нь бие биенийхээ хувийн онцлог чанарыг ойлгон зохицох, зан үйлийн болон сэтгэл хөдлөлийн ойр дотны харилцаатай холбоотой. Ингэснээр хосууд биесээ илүү гүнзгий таниж мэдэх боломж нэмэгдэнэ. Судлаачид эрэгтэй, эмэгтэйчүүд хэн нь гэр бүлийн амьдралд зохицохдхх тийм ч сайн биш болохыг тэдний бие хүний шинж чанараар нь судалжээ.

Тухайлбал: Зарим эмэгтэйчүүд гэр бүлийн амьдралд зохицохдоо тааруу байдаг нь тэд сөргөлдөх дуртай гэрийн ажилд муу, үр хүүхдэдээ санаа тавьдаггүй, нөхрөө шүүмжлэлтэй ханддаг, дэлгэрэнгүй, гэр орноо төдий л анхаардаггүй зөвхөн хувийн сонирхолд автдаг бол эрчүүдийн хувьд аливаад сонирхол муутай, гэр бүлийн материаллаг байдалд санаа зовдоггүй, итгэлгүй, сайн сайхан мэдрэмж тодорхой илэрдэггүй,

хүүхэдтэйгээ ширүүн харьцдаг, өөнтөгч өөрийгөө хөгжүүлэхэд бага анхаардаг зэргээс хамаарна гэсэн байна.

Хоёрдогч дасан зохицолын мөн чанар нь гэр бүлд сөрөг дасан зохицол чвагдаж, гишүүдийн давтагдашгүй онцлог хайр сэтгэл, мэдрэмжийг үнэлж үздэггүй. Энэ нь хүний сайн сайхан мэдрэмжийг бууруулах улам үлбэгэр, хайхрамжгүй байдалд оруулна.

Өөрөөр хэлбэл: Эдгээр нь оюун санаа, ёс суртахуун бэлгийн харилцаа гэсэн 3 үндсэн хүрээнд өөр нөлөөлдөг гэж болно.

Хоёрдогч дасан зохицолын тэмжх нөхцөлүүд байна. Үүнд:

- Өөрийн нэр хүндийг хайртай хүнийхээ өмнө “өргөхийн” төлөө байнга өөрийгөө хөгжүүлэн ажиллах
- Хоорондын харилцааны соёлыг дээшлүүлж, эвсэг, найртай, анхаарал халамжтай байх. Хүний хүнийх нь хувьд хүндэлж сурах.

Гэрлэгсдийн харилцан бие даасан байдлыг хангах

Хэт бие биеэсээ хамааралтай байх хэрэггүй. Түр хугацаагаар хол байх нь зарим үед хосуудын харилцаанд сайнаар нөлөөлөх нь бий. Учир нь ингэснээр бие биеэ үгүүлэх, санах, сайн талуудаа олж мэдэх боломжтой.

Хамтын амьдарлын нөхцөлд залуу хосуудын дасан зохицолын бэрхшээл нь олон учир шалтгааныг нөхцөлдүүлдэг. Тухайлбал дээр дурьдсанчлан харилцагчдийн зан үйл, хувийн онцлог, мөн амьдарлын өөрчлөлтөд бэлтгэгдээгүй байх, залуу хосууд тэдний эцэг эхийн хоорондын харилцааны онцлог гэх мэт.

Цөөхөн жил амьдарч байгаа хосуудын хувьд дасан зохицох, эв нэгдлийн асуудалд анхаарах нь чухал. Тэдний олон жил амьдарсан хосуудтай харьцуулбал гэр бүлийн харилцаан дахь сэтгэл ханамжгүй байдалд хандах хандлага нь тийм ч ялгаатай байдаггүй.

Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах хүчин зүйлүүд

Гэр бүлийн тогтвортой байдал бол хувь хүмүүсийн амьдрал, сэтгэл санаа төдийгүй нийгмийн тогтвортой хөгжилд эерэг нөлөө үзүүлдэгээрээ нийгмийн үнэт зүйл болж байдаг. Иймээс гэр бүлийн тогтвортой байдал, түүний шинж чанар, нийгмийн ач холбогдлыг судлах, гэр бүлийн тогтвортой байдал алдагддаг шалтгаануудыг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх арга замуудыг хайхад судалгааны гол хандлага чиглэгдэх ёстой.

Америкийн социологич У.Берр гэр бүлийн тогтвортой байдлыг “гэрлэхээр өмнө тавьсан зорилгодоо хосууд хүрч чадаж байгаа зорилгоор тодорхойлогдох ёстой” үзэж байсан бол Р.Льюс, Ж.Спиноер нар гэрлэлтийн тогтвортой байдлыг “Гэрлэгсдийн нэг нэгэндээ дасан зохицох, тэдгээрийн хоорондын зохистой харилцаа, аз жаргал, сэтгэл ханамжаа мэдрэх төвшинтэй холбоотой” гэж субъектэд хамааруулан тайлбарлаж байв.

Харин Польшийн эрдэмтэн Я.Щепаньский, Оросын эрдэмтэн Б.Г.Харчев, М.С.Мацковский нар гэр бүлийн тогтвортой байдлыг нийгэм гэр бүлийн холбоонд нь тайлбарлахыг илүү оролцож, гэр бүлийн тогтвортой байдлын шинжүүдийг тодорхойлсон байна.

Гэр бүлийн цагийн менежмент-Гэр бүлийн гишүүдийн амьдралын тэнцвэрийг хадгалж бие биесээ болон хамтдаа утга учиртай чанартай цагийг гаргаж чадахх болон өмнөө тавьсан зорилгодоо цаг хугацаанд нь биелүүлж чадах чадамжийг хэлнэ.

Хоёул хөдөлмөрлөдөг гэр бүлд тулгарах асуудлууд:

Энэ гэр бүлийн асуудал гэдэг нь гэр бүлдээ ажил эрхэлдэг эмэгтэйчүүдийн асуудал гэж хэлж болно. Гэр бүлийн системийг нь тусган авч үзвэл гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаа түгшүүр зовиуртай, нөхөр хүүхдүүдтэйгээ харилцах харилцаа зэрэг нь чухал гэж хэлж болох боловч, энгийнээр хэлбэл хамгийн том асуудал нь хүүхдийн хүмүүжил, ар гэрийн ажил мэргэжилтэй холбоотой асуудлууд юм. Ялангуяа мэргэжил, эцэг эх, хань, ар гэрийн ажил хариуцагчдын үүргийг нэгэн зэрэг хариуцаж байгаа болохоор үүнийгээ биелүүлэхийн тулд цаг зав, амралт, энергиэн зөв хуваарилах шаардлагатай. Энэ шаардлагуудыг нэгэн зэрэг зэрэгцүүлэн биелүүлэх боломжгүй бөгөөд даван туулахад гэр бүл болон ажилтай холбоотой зөрчлүүд үүснэ.

Нэгдүгээрт: Хүүхдийн хүмүүжил болон боловсролын асуудал хамгийн чухал юм. Хүүхдийн цэцэрлэгүүдийн хүчин чадал хүрэлцдэггүй ба бага орлоготой гэр бүлийн эхнэр нь ажил хийвэл хүүхдээ хараа хяналтгүй орхих юм уу орчин нөхцөл муутай газар, хөршүүддээ даатган үлдээх явдлаас болж хүүхдийн өсөлт бойжилтонд муу нөлөө үзүүлсээр байна.

Хоёрдугаарт: Ар гэрийн ажлын асуудал юм. Нөхрүүд ихэвчлэн ажлаа хийхээс биш ар гэрийн ажлаас хол байдаг. Харин эхнэрүүд ажил хийж байгаа боловч ар гэрийн ажлаа хийсээр л байдаг. Энэ байдал нь цомхон бага гэр бүлийн системд шилжсэнтэй холбоотой. Эхнэр, нөхрийн үүргийн хуваарилалтын асуудал, мөн эдийн засгаа өргөжүүлэх зорилго өмнөө тавиад байгаа манай орны бодит байдал нь эрэгтэйчүүдийн үүргийг илүү чухалд тооцож байгаатай холбоотой юм. Дээрээс нь эцгийн эрхт ёсны үзэл баримтлал байсны зэрэгцээ эрчүүд ажил хийх болсон учраас эхнэрүүд ар гэрийн ажлаа илүү сайн хийх шаардлагатай гэж үздэг. Бага орлоготой гэр бүлүүдийн хувьд ажил хийхэд хүндрэлтэй байхад гэрийн ажлаа давхар хариуцах нь үнэхээр хэцүү асуудал болж байна.

Гуравдугаарт: Эхнэр, нөхөр хоёр хоёулаа хөдөлмөрлөдөг гэр бүлүүд хүүхэддээ анхаарал тавьж чаддаггүй ба гэрлэлтэндээ сэтгэл хангалуун эсэх, аз жаргалтай байдаг эсэх, тус тусын үүрэг хариуцлагын байдал нь асуудалтай байна. Үндсэндээ хоёул хөдөлмөрлөдөг гэр бүлүүдийн эхнэр хөдөлмөрлөж буй нь эдийн засгийн байдал нийгэмд эзлэх байр суурь нь тодорхой хэмжээний нэмэр оруулж, гэрийн ажлыг шийдвэрлэхэд нөхрүүд оролцосноор эхнэр нөхрийн хоорондын харилцаа эрх тэгш байж чаддаг юм. Ийм гэр бүлүүдэд гуравны хоёрт нь нэгээс илүү зөрчилдөөн байдаг ба нийгмийн асуудалд санал зөрөлдөх, үр хүүхэдтэйгээ харилцах харилцаа зэрэгт илүүтэйгээр зөрчилдөөн үүсдэг байна. Эхнэрүүд ажиллах нь гэр бүл дэх асуудлуудыг үүсгэх гол хүчин зүйл болох ба хүүхэддээ хангалттай цагийг зарцуулж чадахгүйн дээр нөхөртэйгөө ярилцах, халамжлах цаг хомс, нөхрийн талынхантайгаа харилцаа холбоо муудах зэрэг жишээг дурдаж болно. Ажиллаж буй эхнэрүүдэд өөрийн ажил мэргэжилдээ сэтгэл хангалуун байх, нөхөр нь тусалдаг тохиолдолд дээрх зөрчлүүд тодорхой хэмжээгээр багасдаг байна.

Дөрөвдүгээрт: Ажилдаг гэр бүлтэй эмэгтэйчүүдийн цалингийн хэмжээ нь ихэнх нь доод түвшинд хамрагдаж байна. Ялангуяа бага орлоготой эмэгтэйчүүд гэрлэснийхээ дараа ихэнхдээ сэтгэл хангалуун бус байдаг. Бага орлоготой хоёул ажилдаг гэр бүлүүд нь амьдралаа дээшлүүлэх нь бүү хэл хэрэгцээгээ хангах төдийд л хүрч байна. Ихэнхдээ гэрлэхээсээ өмнөх байдлаасаа амьдрал нь доошилсоор ажил хийхээс аргагүй болсон нь их байдаг. Иймээс эмэгтэйчүүдийн үүрэг хариуцлага нэмэгдэж асуудлууд нь шийдвэрлэгдээгүй хэвээр байсан байна. Иймд ажиллах нөхцлийг сайжруулах, хүйсээр ялгаварлан гадуурхах явдлыг арилгахад хүчээ дайчлан зүтгэх хэрэгтэй.

Эхнэр нөхөр хоёул хөдөлмөрлөдөг хоорондын харилцаа

Эхнэр нь ажил хийснээрээ гэр бүлийн харилцаанд янз бүрийн зөрчил гардаг бөгөөд нэн тэргүүнд эхнэр нөхрийн хоорондох харилцаа юм. Гэрийн тэжээгч, эх хүн, эхнэр, гэрийн үйлчлэгч зэрэг үүргүүдийг нэгэн доор хариуцаж буй эмэгтэйчүүдийн байр суурьнаас авч үзвэл эхнэр нөхрийн харилцаанд өөрчлөлт гарахгүй байхын аргагүй юм. Дагаад үүргийн хэт хүнд байдал, үүргээ хуваарилах, нөхөр нь гэрийн ажилдаа оролцох, гэр бүлээ хамтдаа авч явж байгаагийнхаа хувьд тэгш эрхтэй байх зэрэгт анхаарсан сүүлийн үеийн судалгаа /Солонгос улс гэр бүлийн судлалын хүрээлэн 1991 /- аас үзвэл:

1. Хүйсийн үүргийн талаасаа харахад эхнэр нь боловсролын түвшин өндөр, дээд тушаалын ажил эрхэлдэг тохиолдолд эхнэр нөхөр тэгш эрхтэй байдаг. Мөн өрхийн

орлого өндөр нөхөр эхнэрийнхээ ажлыг дэмждэг гэр бүлүүдэд мөн энэ байдал ажиглагдажээ.

2. Хүйсийн үүргийн зөрчилтэй талаас нь авч үзвэл эхнэр нь ажил орон гэрээ авч явах үүргийг ганцаараа хариуцаж үүнээс үүдэн цагийн хуваарилалтаас болон ядаргаанд орох асуудал гарч иржээ. Эдийн засгийн асуудлаас болж эхнэр нь ажил хийж буй тохиодолд, мэргэжилдээ сэтгэл ханамжгүй байдал бий болж эрэгтэйчүүд давуу эрхтэй байх ёстой гэсэн үзэлтэй болдог байна. Нөхөр нь эхнэрийнхээ ажлыг эсэргүүцдэг, санал нэгддэггүй тохиолдолд, нөхрөөсөө эхнэр нь илүү орлоготой тохиолдолд үүргийн зөрчлүүд илүү их үүсдэг.
3. Эхнэр нөхрийн хоорондын харилцааны талаас үзвэл судалгаагаар өдөрт дунджаар 90-100 минут ярилцдаг ба ихэвчлэн хүүхдийнхээ талаар л ярилцдаг байна. Ойролцоогоор гэр бүлийн 40 хувь нь эхнэр нөхрийн харилцан ярилцах цаг дутагдаж байна. Ихэнх эхнэр нөхрүүд хамтдаа амрах амралтын цаг бараг байдаггүй, эсвэл огт байдаггүй гэж хариулжээ. Гэвч гэр бүлүүдийн ихэнх хувь нь хоёулаа ажил хийх нь бэлгийн амьдралд ямар нэгэн муу нөлөө байдаггүй. Гэхдээ эхнэр нөхрийн 30 орчим хувь нь эхнэр нь ажил хийх нь бэлгийн амьдралд асуудал үүсгэж байна. 10 хувь нь бэлгийн амьдралдаа сэтгэл ханамжгүй байдаг байна. Гэвч дээд албан тушаалын алба хашдаг юм уу тэгш эрхтэй байдаг тохиолдолд эхнэр, нөхөр нь хоёулаа гэрлэлтэндээ сэтгэл хангалуун байдаг ажээ.

Ирээдүйн чиг хандлага

Эхнэр, нөхөр хоёулаа хөдөлмөрлөг гэр бүлүүдийн асуудлуудын талаар авч үзлээ. Нийгэмд түгээмэл тохиолдож буй энэ гэр бүлийн систем нь өнгөрсний уламжлалт хүсийн тэгш бус үүргээс шийдэгдээгүй асуудлуудыг агуулсаар байна. Тэгвэл энэ гэр бүлүүд нь цаашдаа яавал асуулуудаа шийдвэрлэж бүгдээрээ аз жаргалтай болох бол хэмээн бодосны үндсэн дээр хэдэн асуудлуудыг дэвшүүллээ.

1. Гэрлэсэн эмэгтэйчүүдийг нийгэмд уруу татаж нийгэм эдийн засгийн бодлогоо хэрэгжүүлэхийн тулд эмэгтэйчүүдийн ажиллах хүчийг ашиглаж буй орны хувьд хоёул ажилдаг гэр бүлийн эрх ашгийн төлөө ямар нэгэн нэгдсэн бодлого явуулах шаардлагатай.
2. Эхнэрүүд ажил хийх болсонтой холбогдон гарч буй асуудлуудын хамгийн том асуудал нь хүүхдийн хүмүүжил боловсрол, гэрийн ажил юм. Одоог хүртэл энэ хоёр асуудал нь эмэгтэйчүүдийн үүрэх ёстой үүрэг мэтээр ойлгогдсоор байна. Энд шаардагдаж буй зүйл нь эрэгтэйчүүдийн хүйс нь тэгш бус харьцаа болон эцгийн эрхт ёсыг улам дэмжсэн хэрэг юм. Гэр бүл болоогүй эрэгтэйчүүд нь

хоёулаа хөдөлмөрлөж амьдрах эмэгтэйг хайж байдаг бөгөөд энэ эмэгтэйн үүрэгт гэрийн ажлаа хариуцах нь ордог байна. Ялангуяа хүүхдийн хүмүүжил боловсролд хамтран оролцох шаардлагатай бөгөөд гэрийн ажлаа ч хамтран хийхийн тулд гэрийн бүх /жишээ нь: хувцас угаах, хоол бэлтгэх, аяга угаах, дэлгүүр явах, хүүхдээ харах/ ажил хамтран оролцох эрхтэй ингэснээрээ гэр бүлүүд нь хүйсийн тэгш бус харилцааг өөрчилж болох талтай юм.

3. Эмэгтэйчүүдийн эрхийг сэргээх шаардлагатай эхнэр, нөхрийнхөө нэгэн адилаар гэрийн тэжээгчийн хувьд нөхрийн туслагч бус нөхөртэйгөө тэгш эрхтэйгээр үзэгдэх ёстой. Эрэгтэйчүүд одоо заавал өөрийгөө гэр бүлээ тэжээх ёстой гэж үзэх шаардлагагүй юм. Өөрийнхөө мэргэжлээр дамжуулан өөрийгөө бие хүн болж төлөвшүүлэх, ур чадвараа дээшлүүлж ажлын талбартаа тэргүүлэх, өөрийн гэсэн байр сууриа олж авах хэрэгтэй. Энэ нь эмэгтэйчүүдээс давж гарах арга ч гэж хэлж болно. Хүүхдээ өсгөн бойжуулах нь эмэгтэйчүүдийн үүрэг гэдэг боловч, эрэгтэйчүүд улс орон гээд бүхнийг хамтдаа хүлээх үүрэг байх ёстой.
4. Хоёул хөдөлмөрлөх гэр бүл нь шинжлэх ухаан талаасаа нь ч үзсэн хамтарсан гэр бүлийн үүргийг ухаарах хэрэгтэй юм. Гэрийн ажлыг хөнгөвчлөх гэр ахуйн цахилгаан барааг хэрэглээгээ болгон гэр бүлийн бүх гишүүд гэрийн ажилд гар бие оролцдог тогтолцоог бий болгох хэрэгтэй.

Хүснэгт 1-1 Гэрлэлт ба гэр бүлийн хэлбэр, хэв маяг онцлог

Моногами (monogamy) гэр бүл	Нэг эрэгтэй нэг эмэгтэйгээ гэрлэх
Полигини (polygyny) гэр бүл	Нэг эрэгтэй олон эмэгтэйтэй гэрлэх
Полиандри (polyandry) гэр бүл	Нэг эмэгтэй олон эрэгтэйгээ гэрлэх
Дан гэр бүл	Эцэг эх, үр хүүхдүүдээс бүрдсэн гэр бүл
Нийлмэл гэр бүл	Дан гэр бүлийн гишүүд аав, ээж эсвэл хадмууд, хамаатан саднуудаар өргөжсөн
Өрөөсгөл гэр бүл	1. Эцэг ба хүүхэд 2. Эх ба хүүхэд 3. Бусад /хүүхдүүд эмээ, өвөө+ач, зээ/
Ганц бие гэр бүл	Хувь хүн, гэр бүлийн харилцаа холбоо, ойлголцол, тусламж дэмжлэгээс түр зуур эсвэл байнга, аргагүйн эрхэнд, эсвэл сайн дурын үндсэн дээр гэрлэхээс татгалцан амьдрах хэлбэр

Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, хэрэгцээ үйлчилгээ
/Дундговь аймгийн жишээн дээр/

Байршилгүй гэр бүл	Гэрлэгсэд тус тусын эцэг эхийн гэрт амьдарч хааяа уулзаж хамт амьдардаггүй гэр бүлийн хэлбэр
Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гэр бүл	Гэр бүлийн гишүүний хэн нэг нь өөрийн хүч, эрх мэдлээр давамгайлан бусад гишүүдийг хүчирхийлдэг гэр бүл
Олон соёлт гэр бүл	Өөр хэл, соёл, ёс заншил бүхий иргэд гэрлэлтийн харилцаа үүсгэж гэр бүл болсныг олон соёлт гэр бүл гэнэ.
Улс дамнасан гэр бүл	Гэр бүлийн гишүүд хамтдаа амьдрахгүй өөр өөр улсад амьдрахыг улс дамнасан гэр бүл гэнэ
Гэрээт гэр бүл	Эхнэр нөхөр 2 харилцан тохиролцсоны үндсэн дээр тодорхой хэлцлээр гэрээ байгуулан гэр бүл болохыг хэлнэ.
Шилжин суурьшсан гэр бүл	Уугуул нутгаасаа шилжин өөр газар суурьшсан гэр бүлийг шилжин суурьшсан гэр бүл гэнэ.
Залуу гэр бүл	35 хүртэлх насны гэр бүл
Дунд насны гэр бүл	35-55 насны гэр бүл
Ахмад насны гэр бүл	55-аас дээш насны гэр бүл
Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүл	Гэр бүлд төрөлхийн болон олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болсон гишүүн байгаа гэр бүл
Анхны гэрлэлт	Гэр бүлийн эхнэр нөхөр хоёр анх удаа гэрлэлтийн харилцаа үүсгэж байгаа гэр бүл
Дахин гэрлэлт	Анхны гэрлэлтээ цуцлуулсан, эсвэл бэлэвсэрсэн тохиолдолд шинээр гэр бүл үүсгэж буй хэлбэр
Ижил хүйстэн	Ижил хүйсийн хүмүүс сэтгэл санаа болон бэлгийн харилцаанд үндэслэн гэрлэх
Эцгийн эрхт гэр бүл	Эрэгтэй нь эрх мэдэлтэй байдаг гэр бүл
Эхийн эрхт гэр бүл	Эмэгтэй нь эрх мэдэлтэй байдаг гэр бүл
Эрх тэгш гэр бүл	Эхнэр нөхөр хоёр эрх тэгш эрх мэдэлтэй байдаг гэр бүл

Гэр бүлийн талаарх үзэл ойлголт нь тухайн цаг үеэс шалтгаалж янз бүрээр өөрчлөгддөг байна. Монгол гэр бүлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг судлах, тэдний хэрэгцээ шаардлагад үндэслэн гэр бүлийг дэмжих үйлчилгээний хувилбаруудыг боловсруулах зорилго бүхий “Монгол гэр бүлийн асуудал, хэрэгцээ үйлчилгээний хувилбар” судалгаагаар 11 хэв шинжийн гэр бүл судлагдсан байдаг²³. Үүнд:

Ядуу гэр бүл нь амьдралын чанарыг тодорхойлогч хүнс тэжээл, хувцас, гэр орон зэрэг ердийн хэрэгцээний дутагдал гачигдалтай амьдарч байгаа бөгөөд эрүүл мэнд, боловсрол, оюуны болон биеийн чадавх доройтох, хоол тэжээлийн хомсдол, бараа үйлчилгээний дутагдалд орох, дэд бүтцийн үйлчилгээнүүдийн хүртээмж хязгаарлагдмал, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх чадвар хангалтгүй байгаагаар илэрнэ.

Олон хүүхэдтэй гэр бүл нь гурав болон түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийг хэлнэ. 2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1. “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг;

Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүлийг хэлнэ. Гэр бүлд төрөлхийн болон олдмол хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүл гэж ойлгоно.

Өрөөсгөл гэр бүл гэж цуцлалт, нас баралт болон бусад шалтгаанаас үүдэлтэй эцэг эхийн аль нэг нь байхгүй өрх толгойлсон эцэг эсвэл эхтэй гэр бүлийг хэлнэ.

Архины хамааралтай гэр бүл гэдэг нь гэр бүлийн гишүүн нь өнгөрсөн 12 сарын турш ямар ч хугацаанд уухдаа уултын хэмжээгээ нэмэгдүүлсэн, бие физиологи болон сэтгэл зүйн хувьд архины хамааралтай, архины нөлөөнд тэсвэртэй, архитай холбоотой шинж тэмдгүүд тодорхой болсныг хэлнэ.

Дахин гэрлэсэн гэр бүл гэдэг нь эхнэр, нөхрийн аль нэг нь эсвэл хоёул бэлэвсэрсэн эсвэл өмнөх гэрлэлтээ цуцалсны дараагаар өөр хэн нэгэнтэй гэрлэлтийн холбоо үүсгэсний улмаас өмнөх гэрлэлтээр төрүүлсэн эсвэл үрчилсэн хүүхэд нь хойд эх эсвэл эцгийн хамтаар амьдарч буй гэр бүлийг хэлнэ.

Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасныг үндэслэн

Хүчирхийлэлтэй гэр бүл гэдэг нь эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээдийн зүгээс бусад хамаарах хүний сэтгэл

²³Монгол гэр бүлийн асуудал, хэрэгцээ үйлчилгээний хувилбар” судалгааны тайлан .(2018) Уб,80-р тал

санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүй тохиолддог гэр бүлийг хэлнэ.

Түр хугацаагаар тусдаа амьдарч байгаа гэр бүл бол эхнэр, нөхрийн аль нэг нь гадаадад байгаа, үндсэн гэр бүлтэйгээ амьдардаггүй, баталгаат гэр бүлтэйгээ амьдардаггүй нөхцөл байдлыг ойлгоно.

Шилжин суурьшсан гэр бүл гэдэгт уугуул нутгаасаа өөр газар шинээр суурьшиж эхэлж байгаа гэр бүлийг ойлгоно.

Хэвийн гэр бүл гэдэг нь гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий, нийгмийн халамж дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагагүй гэр бүлийг хэлнэ.

Зураг 1-1 Гэр бүлийн хэлбэр, хэв шинж



1.2 Залуу гэр бүлийн сэтгэл зүй, нийгмийн харилцааны онцлог

Гэр бүлийн амьдралын мөчлөг нь хос хоёроос эхэлдэг. Өөр өөр орчинд өссөн хоёр хүн насан туршдаа хамт амьдрах зохицлыг бий болгох хэрэгтэй болдог. Тэд бие биенийхээ хил хязгаар руу аажмаар ордог. Яагаад гэвэл эдгээр жилүүд нь тэдний хувьд амьдралын суурийг тавих цаг тул залуу хосууд хянамгай алхах хэрэгтэй. Хүүхэдгүй байх цаг хугацаа нь өөрсдийгөө таньж мэдэхэд тусладаг. Өөр хэн нэгэн хүн амьдралыг хуваалцахаас өмнө

бие биенээ мэдэх нь илүү дээр юм. Тиймээс хосууд баг болсон гэдгээн ухамсарлах ёстой. Өдөр бүр нэг хүн биш харин одоо хоёр хүний талаар бодолцох ёстой болж байна. Бие биедээ итгэх найдахыг болон хувийн онцлог чанарыг нь хэрхэн дэмжихэд суралцах ёстой.

Залуу нас нь хүний бие махбодийн хөгжил хамгийн эрчимтэй явагдах учраас энэ насны эрэгтэй, эмэгтэй хүмүүс бусад насныхантай харьцуулахад биеийн тэнхээ тэсвэр тэвчээр сайтай байдаг.

Насанд хүрэгчдийн бие, сэтгэцийн хөгжлийн асуудлыг авч үзэхдээ ихэнх судлаачид Эриксоны нийгэм сэтгэл зүйн онолыг тулгуур болгосоор ирсэн. Эриксоны онолд нэг үе шатны хөгжил дараагийн үе шатны хөгжлийн үндэс болж өгдөг хэмээн баталдаг. Насанд хүрэх хөгжлийн үйл явц өмнөх үе шатны асуудлуудыг шийдвэрлэх, тухайлбал:

- > өөртөө итгэх,
- > бие даах,
- > идэвхи санаачлага бий болох,
- > хөдөлмөрч чанар төлөвших явдалтай холбоотой илэрдэг.

Залуу насны үед шийдэх ёстой хамгийн гол асуудал бол ганцаардах юмуу, бусадтай өөрийгөө бүх талаар адилтган үзэхээс хөндийрч, өөрийгөө эрж олох явдал байдаг.

Хүний хөгжлийн онол: Америкийн сэтгэл зүйч Эрик Эриксон /Епсэеп Епс/ (1902-1994) нь хүний хөгжлийг 8 үе шат болгон загварчилсан. Хөгжлийн үе шат бүр өвөрмөц маягийн зөрчил үүсгэх нөхцөл бүрэлддэг бөгөөд уг зөрчлийг хэрхэн шийдвэрлэснээс тухайн шатны эцсийн үр дүн эерэг байх уу сөрөг байх уу гэдэг нь шалтгаална. Эриксон онолдоо хүний би буюу эго-гийн төлөвшлийг голлон анхаарсан.

Залуучуудад сэтгэц, нийгэм, бие махбод, оюун санааны маш олон төрлийн хэрэгцээ байдаг. Харин энэ насныхан хэрэгцээгээ үерхэл нөхөрлөлийн харилцаанаас илүү их хайдаг.

Залуучуудын сэтгэл зүйн хэрэгцээ:

- Сэтгэл хангалуун байж, өөртөө итгэх
- Мэдрэмжээ бусадтай хуваалцах
- Баярлаж хөгжилдөх
- Энхрийлүүлж хайрлуулах
- Мөрөөдөл, дотоод сэтгэлээ хуваалцах

Залуучуудын нийгмийн хэрэгцээ:

- Гэр бүлийн гишүүн байх
- Бусдын анхаарлын төвд байх, өөрийгөө үнэлүүлэх
- Нийгэм хамт олны гишүүн байх, бие хүн болсноо мэдрэх гэсэн²⁴эдгээр сэтгэл зүйн болон нийгмийн хэрэгцээнүүд нь залуучуудын хувьд залуу гэр бүлийн хувьд онцлог нь болж байдаг байна. Залуу гэр бүлд тэдний сэтгэл зүй болоод нийгмийн бусад нөлөөллөөс үүдэн бий болсон асуудлууд их байдаг. Үүнийг шийдвэрлэхийн тулд хүн өөрийгөө таньж мэдэх, өөрийн давуу болон сул талаа бодитоор үнэлэх, өөрийгөө хөгжүүлэх, бусадтай харилцах харилцааны ур чадварт суралцах хэрэгтэй болдог.

Залуучуудын сэтгэхүйн хэв шинжийн онцлог:

- Айдас түгшүүр маш багатай
- Хийсвэрлэх сэтгэхүйгээс бодит ертөнцөд тулгуурласан сэтгэхүй зонхилдог.
- Эсрэг тэсрэг үзэл санааг нэгтгэж, харьцуулж бусад бодит байдалтай уялдуудах замаар шийдвэр гаргах, сэтгэл зүйн процесс хүчтэй хөгждөг.
- Танин мэдэхүйн төлөвшлийн шалгуур болох үүрэг хариуцлага харьцангуй дээшилсэн байдаг.
- Хүүхэд наснаас насанд хүрэх хөгжлийн үе дууссан байна.
- Авьяас билгээ хөгжүүлэх, албан тушаал дэвших гэх мэт амьдралын хэв шинжээ тодорхойлох арга ухаанд суусан байна.
- Амьдрал үйл ажиллагаагаа илүү ухаалаг алсын бодолтой хандаж, бие дааж ухаалгаар шийдвэрлэх чадвартай.
- Оюуныхаа чадварыг ашиглах арга чадварт суралцсан байдаг. Өөрөөр хэлбэл залуу насны буюу бүр тодруулбал 26-35 насанд залуучууд илүү бие даасан бусдаас хараат бус болсон байдаг гэсэн хандлага ашиглагдаж байна. Тэгэхээр энэ насандаа гэр бүл зохиож амьдрах нь тохиромжтой байхаар харагдаж байгаа юм.

Залуу гэр бүлд тулгамдаж буй нийгмийн асуудал

2003 оноос хэрэгжиж эхэлсэн “Төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилт нь дэвшүүлсэн асуудлаа амжилттай хэрэгжүүлж, үндсэн суурь асуудлууд болох гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан салбар газрууд болон тухайн чиглэлд үйлчлэх мэргэжилтнүүдийг амжилттай бэлтгэснээс үндэс сууриа сайн тависан байгаа нь харагдаж байна.

²⁴ Оюун-Эрдэнэ Б. “Залуу гэр бүлд зориулсан сургалтын модуль” 2020 он

“Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” 2010 онд хийгдсэн судалгааны дүнгээс харвал залуу гэр бүлүүдэд тулгамдаж буй үндсэн асуудлууд нь *нэгдүгээрт*: орон сууц, *хоёрдугаарт*: мөнгө санхүү, *гуравдугаарт*: ажил олдохгүй байдал²⁵ гэсэн шалтгаануудыг дурдсан байдаг. Эдгээр шалтгаануудыг ажиглаж харвал бүгд нийгмийн зүгээс улбаатайгаар үүсэж буй асуудал гэж хэлж болохоор байна. Өнөөдрийн байдал дээр аваад үзвэл хэдийгээр 12 жилийн өмнө хийгдсэн судалгааны үр дүн боловч дээрх гурван хариулт нь дундговь аймгийн залуу гэр бүлүүдийн өмнө тулгамдсан асуудал хэвээр байгаа гэж таамаглаж байна. Мөн энэ насны залуучуудын дунд ажиглагдаж буй нийтлэг хандлага бол гэр бүл төлөвлөлт хийхгүйгээр зөвхөн “хайр сэтгэл”-дээ хөтлөгдөн яаран гэр бүл болдог нь цаашид гэр бүлийн амьдралын жилүүдэд нийгэм, хүрээлэн буй орчноосоо ирэх аливаа асуудалд бэлэн биш, ул суурьтай хандаж чадахгүй хөнгөн шийдвэр гаргаж, улмаар гэр бүл салах гэх зэргээр тогтворгүй гэр бүлийг бий болгох нөхцөл бүрдүүлж байдаг байна.

Доктор, дэд профессор Б.Оюун-Эрдэнэийн судлан тодорхойлсноос харвал залуу гэр бүлүүдэд дараах асуудлууд тулгамдаж байна.

- Гэрлэлтээс хүлээх хүлээлт, гэрлэлтийн бодит, үнэн хоёрын зөрүүтэй байдлаас үүдсэн гомдол
- Гэрлэгсдэд гадаад ба дотоод хил хязгаарыг тогтоож чадаагүйгээс хамаатан садан, найз нөхдийн нөлөөллөөс үүдэлтэй зөрчил маргаан
- Анхны хүүхдээ асарч хүмүүжүүлэх, эрүүл чийрэг өсгөн бойжуулахад туршлага дутах
- Мөнгө санхүүгийн хэрэгцээгээ хангах асуудал
- Орон байрны асуудал
- Хүүхэд мэндэлснээс хэн нь хүүхдээ өсгөж бойжуулах тухай асуудал
- Бие биенийхээ эцэг эхтэй харилцаа холбоонд орж, амьдралын шинэ нөхцөлд дасан зохицох асуудлууд
- Төрж өссөн гэр бүлийн орчин болон, өөрийн эцэг, эхийн хайр халамжийг хадмуудаасаа хүсэх байдал
- Бие биенийхээ үнэн төрхийг мэдсэнээр урам хугарах асуудал

²⁵ Оюун-Эрдэнэ Б. “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” судалгааны тойм УБ, 2010

- Амьдралын туршлага бага, аливаа асуудалд сэтгэл хөөрлөөр хандах, хүүхэдтэй болж хүмүүжүүлэх, ажил дээр гарч албан тушаалд дэвших, буурах, тусдаа гарч бие даан амьдрах гэх зэрэг олон өөрчлөлттэй тулгардаг²⁶.

Харин доктор, профессор Т.Намжил гэр бүлийн өмнө тулгамдаж буй асуудлыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд.

- Улсын нийт өрхийн бараг тал хувь нь нийслэлдээ амьдарч байгаа
- Өрхийн тал хувь уламжлалт сууж гэртээ амьдардаг
- Огт гэрлээгүй хүмүүсийн эзлэх хувь нэмэгдэж байгаа
- Анхны гэрлэлтийн дундаж нас нэмэгдсэн
- Угийн бичиг хөтөлдөг, хожуу гэрлэлт нь нийгмээс хамаарахгүй хувь хүний болон гэр бүлийн чөлөөт сонголтоос шалтгаалах
- Хүүхдээ амьдралд бэлтгэхэд эцэг эх, гэр бүлийнхнийх нь үүрэг оролцоог чухалчлах хэрэгтэй болсон
- Гэр бүлийн тав тухгүй орчноос шалтгаалан тэнэмэл хүүхэд, бие үнэлэгчид бий болж, гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа
- Гэр бүлийн жендэрийн уламжлалт хөдөлмөрийн хуваарь нь үндсэндээ хадгалагдсаар байгаа боловч тодорхой өөрчлөлтүүд орж байгаа
- Өрхийн бүтцийн хувьд дан өрх дийлэнх хувийг эзэлж байгаа боловч гэр бүлийн олон хэлбэрүүд бий болж байна.
- Ёс заншил, уламжлалыг гэр бүлийнхэндээ сургах, хэвшүүлэх, түүнчлэн хүүхдээ ажил хөдөлмөрт сургах, хүүхдийн эрхийг хамгаалах, үүргээ биелүүлэхэд нь туслах талаар эцэг эхчүүдийн үүрэг оролцоо дутагдалтай хэмжээн дүгнэсэн байна.²⁷

Төрөөс залуу гэр бүлийн талаар хэрэгжүүлж буй бодлого, эрх зүйн орчин

Гэр бүлийн хөгжил нь нийгмийн хөгжлийг тодорхойлогч гол хүчин зүйлийн нэг юм. Тиймээс ч улс орон бүр залуу гэр бүлийг дэмждэг. Дундговь аймаг төдийгүй Монгол улсад залуу гэр бүлийг хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд нь туслах, богино хугацааны тусламж үзүүлэх, тэтгэлэг олгох, байр орон сууцаар дэмжих, хөдөлмөрт бэлтгэх зэрэг залуу гэр

²⁶ Оюун-Эрдэнэ Б. “Гэр бүлийн боловсрол” УБ, 2016 75-р тал

²⁷ Намжил Т. Ц.Энхтүвшин “Гэр бүлийн хөгжлийн асуудал” 17, 18-р тал

бүлийг дэмжих тогтолцоо сул байна. Тиймээс гэр цуцлалтын тоо жил ирэх тусам өссөөр байна.

Монголын төр засгаас авч хэрэгжүүлсээр ирсэн гэр бүлийн бодлогын тойм:

- 1992 он: Хүн амын бодлого, хөдөлмөрийн яаманд эмэгтэйчүүдийн тасаг байгуулагдан гэр бүл, эмэгтэйчүүд, хүүхдийн асуудлаар бодлого боловсруулан хэрэгжүүлж байсан гэсэн мэдээ байна.
- 1996: Улсын их хурлын тогтоол “Монгол улсын төрөөс баримтлах хүн амын бодлого”-д гэр бүлийг чухал ач холбогдолтойд тооцон “Гэр бүл нь хүний амьдарлын анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж гэж үзэж түүний хөгжлийн тухай асуудлыг төрийн бодлогын анхааралд байлгах” гэж онцолсон байна.
- 1999: Гэр бүлийн тухай хуулийн батлан хэрэгжүүлж эхлэв. Уг хууль гарснаас гэр бүлийн өмнө тулгарсан асуудлыг хууль, эрх зүйн орчинд нь шийдвэрлэх боломжтой болоод зогсохгүй, гэр бүлийг нийгмэ, төр засгийн хүрээнд чухал ач холбогдолтойд тооцож, анхаарах болсон юм.
- 2003: УИХ-ын 16-р тогтоолоор “Монгол улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан байдаг. Энэ нь гэр бүлийг төрийн оролцоотойгоор олон талт байдлаар дэмжих болсноороо чухал ач холбогдолтой юм.
- 2004 он: Улмаар УИХ-ын 21-р тогтоолоор “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-д гэр бүл нь хүний амьдарлын анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж гэж үзэж, түүний хөгжлийн тухай асуудлыг төрийн бодлогын төвд байлгах гэж онцлон заасан байдаг.
- 2006 он: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль баталснаар хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгддэг хүчирхийллийг бууруулах боломж бүрдсэн юм.
- 2016 он: “Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-д “хүн амын тогтвортой хөгжлийн хангах, иргэдийн урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчныг бүрдүүлэх, хувь хүн болон гэр бүлийн амьддарлын чанарыг дээшлүүлнэ” гэж тусгасан байдаг.

- 2016 он “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-д “гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох” гэж тусгасан байдаг.

Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого (2003-2018 он) :

Залуу гэр бүлийг дэмжинэ:

1/залуу гэр бүлийг орон сууцтай болохыг дэмжих хөнгөлөлттэй, урт хугацаатай зээлийн сан, түрээс/лизинг/-ийн үйлчилгээ, оюутны гэр бүлийн хүүхдэд зориулсан сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага хөгжүүлэх зэргээр залуу гэр бүлд нийгмийн таатай орчин бүрдүүлэх;

2/залуучуудын гэр бүлийн талаархи мэдлэг, ойлголт, хандлагыг судалж, уламжлал, шинэчлэлийн асуудлаар хэлэлцүүлэг, ярилцлага зохиох; 3/залуучууд, өсвөр үеийнхэнд бэлгийн амьдралын зохистой мэдлэг, соёл, зөв зан үйл төлөвшүүлэх;

4/залуучуудад бие дааж шийдвэр гаргах чадвар эзэмшүүлэх төсөл, шинээр гэр бүл бологсдод туслах зорилгоор гэргий болон өрхийн тэргүүнийг бэлтгэх сургалт зохион байгуулах ажлыг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.²⁸

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025 он)

4.3. “Гэр бүлийн амьдралын таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг сайжруулах” чиглэлээр дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

4.3.1. хүүхдэд бага наснаас нь эхлэн гэр бүлийн боловсрол олгох, ялангуяа өсвөр үе, залуучуудад гэр бүлийн амьдралд бэлтгэх, амьдралаа зөв авч явах, хариуцах чадварыг эзэмшүүлэх;

4.3.2. хүн амын удмын санд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, урьдчилан сэргийлэх, цус ойртолтыг үгүй болгох;

4.3.3. гэр бүлийн гишүүдийн тэгш эрх, үүрэг, хариуцлага, оролцоог хангах;

²⁸ УИХ-ын 16-р тогтоол “Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын 4.6 дах заалт. 2003 он

4.3.4. хүүхэд бүрийг гэр бүл, нийгмийн ээлтэй орчинд эсэн мэнд, аюулгүй, хүчирхийллээс ангид өсөх орчныг бүрдүүлэх;

4.3.5. гэр бүлийн харилцааны тогтвортой байдлыг дэмжих;

4.3.6. гэр бүлийг орон сууц, газар болон амьжиргааны олон талт эх үүсвэртэй болоход нь дэмжлэг үзүүлэх;

4.3.7. гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, гэм буруутай этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх;

4.3.8. олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй болон өрх толгойлсон эцэг, эх бүхий гэр бүл, ганц бие ахмад настанд дэмжлэг үзүүлж амьдралын түвшинг дээшлүүлэх;

4.3.9. хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн үйлчилгээг хүртэх, гэр бүл, нийгмийн амьдралд идэвхтэй, тэгш оролцоход ээлтэй, хүртээмжтэй орчныг бий болгох.²⁹

Залуучуулын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (2019-2021 он)

Зорилт 3.8. Залуу гэр бүлд амьжиргаагаа дээшлүүлэх, хүүхдээ хүмүүжүүлж хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг тэдний оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.

3.8.1. Гэр бүлийн хөгжлийн төвийг байгуулан ажиллуулах санал санаачилгыг дэмжин түүний үйлчилгээнд залуу гэр бүлийг хамруулах, өсвөр үе, залуучуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх асуудлаар зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэх;

3.8.2. Гэр бүл болсон залуучуудад бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх урт хугацааны зээл, лизингийн үйлчилгээг өргөжүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагыг дэмжих;

3.8.3. Залуучуудын дунд өсөн нэмэгдэж байгаа гэр бүлийн "хамтран амьдрах" хэлбэрийг холбогдох хууль тогтоомжид тусгах, хамтын хариуцлагыг өндөржүүлэх;

3.8.4. Залуу гэр бүлийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалд онцгой анхаарал хандуулж, хүүхэдтэй байхыг дэмжих эдийн засгийн механизм бий болгох.³⁰

Манай улс 2003 оноос хойш гэр бүлийн хөгжлийн тал дээрх чиглэлүүдийг өмнөө тавин ажиллаж байгаа ч гэр бүлийн бүтцэд өөрчлөлт гарч төрийн зүгээс анхаарлаа

²⁹ МУЗГ-261-р тогтоолын хавсралт “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын 4.3 дах заалт, 2016 он

³⁰ МУЗГ-ын 171-р тогтоолын хавсралт “Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” 2019 он

Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, хэрэгцээ үйлчилгээ
/Дундговь аймгийн жишээн дээр/

хандуулж тодорхой ажлуудыг хийж эхэлсэн. Энэ хүрээнд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас өнгөрсөн жилүүдэд гэр бүл, эх, хүүхдийн нийгмийн хамгааллыг сайжруулах талаар багагүй арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Хүн амын өсөлт, өрх гэр бүлийн хөгжлийг дэмжих, эдийн засгийн зарим арга хэмжээг авч эхэлсэн нь Засгийн газраас гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн нийгмийн хамгааллын асуудлуудын нэг юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1. Судалгааны зорилго, зорилт, таамаглал

Судалгааны зорилго:

Дундговь аймгийн залуу гэр бүлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг судлах, тэдний хэрэгцээ шаардлагад үндэслэн залуу гэр бүлд чиглэсэн үйлчилгээг нэмэгдүүлэх

Судалгааны зорилт:

- Залуу гэр бүлийн талаарх онолын үзэл баримтлалыг судлах
- Залуу гэр бүлийн амьдралд нөлөөлж буй нийгэм эдийн засаг, улс төрийн хүчин зүйлс, төрөөс баримталж буй бодлого
- Залуу гэр бүлийн амьжиргаа, харилцаа, сэтгэл зүй, эрүүл мэндийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал
- Залуу гэр бүлийн хэрэгцээ, хэрэгцээ шаардлагад үндэслэн залуу гэр бүлд чиглэсэн үйлчилгээг нэмэгдүүлэх


Судалгааны таамаглал: Дундговь аймгийн залуу гэр бүлийн тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, залуу гэр бүлд чиглэсэн хөгжлийн үйлчилгээ үзүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

2.2 Судалгааны загвар ба аргачлал:

Судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримтын шинжилгээ, тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан хэрэглэнэ. Үүнд:

№	Судалгааны аргачлал	Тайлбар
1	Асуулгын арга	Урьдчилан боловсруулсан асуулгын хуудсыг Дундговь аймгийн 15 сумын 18-34 насны залуу гэр бүлээс авна.
2	Эксперт ярилцлага	Орон нутгийн удирдах түвшний ажилтнуут, өмгөөлөгч, цагдаа, шүүхийн асуудал хариуцсан мэргэжилтэнгүүд, сумдын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтнүүд

Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, хэрэгцээ үйлчилгээ
/Дундговь аймгийн жишээн дээр/



Асуулга: Гэр бүлийн хэв маяг, өнөөгийн байдал, гэр бүлд нөлөөлж буй хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, хэрэгцээ шаардлагагыг тодруулах зорилгоор асуулга судалгаа авав.

Эксперт ярилцлага: Орон нутгийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, өмгөөлөгч, цагдаа, шүүхийн асуудал хариуцсан мэргэжилтэнүүд, сумдын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтнүүдээс гэр бүлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, хэрэгцээ, үйлчилгээг тодруулав.

Баримт бичгийн шинжилгээ: Аймгийн хэмжээний гэр бүлийг дэмжихтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүд, статистик тоо баримтууд, залуу гэр бүлийг дэмжих хөгжлийн үйлчилгээтэй холбоотой бичиг баримтуудыг судлав.

2.3 Мэдээлэл цуглуулах процесс, аргачлал, арга хэрэгслүүд:

Судалгаанд нийт 805 гэр бүл хамрагдсан бөгөөд үүнээс төрийн албан хаагч 423, хувиараа хөдөлмөр эрхлэгч 67, малчин 174, ажил эрхэлдэггүй 86, аж ахуй нэгжид ажил эрхэлдэг 55 гэр бүл тус тус хамрагдсан байна. Гэр бүлийн бүтцээр нь харвал дан гэр бүл 77.1, хэвийн гэр бүл 14.9, бусад хэвийн маягийн 8 хувь байв.

1	Адаацаг	1%
2	Баянжаргалан	5%
3	Хулд	2%
4	Говь-Угтаал	11%
5	Гурвансайхан	7%
6	Дэрэн	2%
7	Дэлгэрцогт	3%
8	дэлгэрхангай	18%

Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, хэрэгцээ үйлчилгээ
/Дундговь аймгийн жишээн дээр/

9	Луус	1%
10	Өлзийт	4%
11	Өндөршил	12%
12	Сайнцагаан	27%
13	Сайхан-Овоо	1%
14	Цагаандэлгэр	2%
15	Эрдэнэдалай	4

Судалгааны мэдээллийг нийгмийн мэдээлэлд статистик боловсруулалт хийх SPSS программыг ашиглан боловсруулав.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ: ЗАЛУУ ГЭР БҮЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, АМЬЖИРГАА,
ХАРИЛЦАА, СЭТГЭЛ ЗҮЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛД
БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ /ДУНДГОВЬ АЙМГИЙН ЖИШЭЭН
ДЭЭР/**

3.1 Дундговь аймагт залуу гэр бүлийн талаар баримталж буй бодлого

Монгол Улсын Их Хурлаас 2020 онд батлан гаргасан “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулинд дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна гэж заасны дагуу Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл төлөвлөгөөг 2020 онд Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, 2020 онд Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл төлөвлөгөө, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Дундговь аймгийг 2018-2028 онд хөгжүүлэх хэтийн зорилт”, салбарын хөгжлийн зорилтот хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан боловсруулсан байна. Энэхүү бодлогын баримт бичигт хүний хөгжлийн бодлогыг дэмжих чиглэлээр 1 зорилгын хүрээнд 4 агуулгаар дэд зорилго дэвшүүлж, 16 зорилтыг хэрэгжүүлэх 73 арга хэмжээг төлөвлөн гаргасан байна.

Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлээс гэр бүлийн талаарх тусгагдсан арга хэмжээнээс:

ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖИЛ

Зорилго 2. Нийгмийн суурь үйлчилгээг хүртээмжтэй хүргэж хүний хөгжлийн индексийн үзүүлэлтийг 2019 онд 0.689 байгааг 2025 онд 0.709 болгож өсгөнө.

Гэр бүл

Зорилго 2.3 Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хөгжил, хамгааллыг сайжруулна.

Зорилт 2.3.1 Гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих чиглэлээр сургалт нөлөөллийн үйл ажиллагааг нийт гэр бүлийн 30 хувьд хүргэнэ.

2.3.1.1 Гэр бүлийн боловсрол олгох сургалт, зөвлөгөөг зохион байгуулна

2.3.1.2 Түр хамгаалах жишиг байр бий болгоно.

2.3.1.3 Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийг стандартын өрөөтэй болгож, хосуудын гэрлэх ёслолын үйл ажиллагааг зохион байгуулна.

Дундговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс гэр бүлийн талаарх тусгагдсан арга хэмжээнээс:

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Зорилго: 2 Хүний хөгжлийг дэмжин иргэдийн ажилтай, орлоготой байх нөхцлийг бүрдүүлэн, хүний хөгжлийн үзүүлэлт 2019 онд 0.689 байсныг 2024 онд 0.719 хувиар нэмэгдүүлнэ.

2.1 Эрүүл мэнд

Зорилго: 2.1 Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж хүн амын дундаж наслалт 2019 онд 74.03 байсныг 2024 онд 75-д хүргэнэ.

Зорилт: 2.1.1 Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлт 2019 онд 57.8 байсныг 2024 он гэхэд 67.4 хувьд хүргэнэ.

Зорилт: 2.1.2 Эхийн эндэгдэлгүй ажиллаж, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулан тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 2019 онд 10.8 байсныг 2024 онд 9 хүргэж бууруулна.

2.2 Боловсрол

Зорилго: 2.3. Сургалтын чанарын үнэлгээний дундаж 2019 онд 39.1 хувь байсныг 2024 онд 47 хувьд хүргэнэ.

Зорилт: 2.3.1 Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2020 онд 72.5 хувь байсныг 2024 онд 76 хувьд хүргэнэ.

Зорилт: 2.3.2 ЕБС-ийн бага, суурь боловсролын хамран сургалт 2020 онд 91.6 хувь

Зорилт: 2.3.3 МСҮТөвийг Магадлан итгэмжлэгдсэн Политехник коллеж болгож, төгсөгчдийн ажил эрхлэлт 2020 онд 65 хувь байсныг 2024 онд 70 хувьд хүргэнэ.

2.3 Гэр бүл

Зорилго: 2.4 Хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн хөтөлбөр, арга

хэмжээг хэрэгжүүлж, ажиллах хүчний оролцооны түвшин 2019 онд 74.8 хувь байсныг 2024 онд 77.2 хувьд хүргэнэ.

Зорилт: 2.4.1 Хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтыг 2020 онд 11198 байсныг 2024 онд 12218-д хүргэнэ.

Зорилт: 2.4.2 2019 оны байдлаар ажиллаж байгаа 22040 иргэний байнгын ажлын байрыг 460-аар нэмэгдүүлнэ.

Зорилт: 2.4.3 Ахмадад ээлтэй сум, баг, байгууллага 2019 онд 24 байсныг 2024 онд 36-д хүргэнэ.

Зорилт: 2.4.4 Хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн хөтөлбөрийн хэрэгжилт 2019 онд 85 хувь байсныг 2024 онд 90 хувьд хүргэнэ.

Зорилт: 2.4.5 Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын дундаж хувь 2019 онд 22.3 байсныг 2024 онд 45 хувьд хүргэнэ

2.4 Үндэсний бахархал, өв соёл

Зорилго: 2.5 Иргэдийг соён гэгээрүүлэх, монгол өв соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо 2019 онд 294454 байсныг 2024 онд 37120-оор нэмэгдүүлнэ.

Зорилт: 2.5.1 Соёл, урлагийн салбарын насжилт өндөртэй барилга байгууламжийн тоо 2020 онд 14 байгааг 2024 онд 50 хувиар бууруулна.

Зорилт: 2.5.2 Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны эзлэх хувь 2020 онд 60 байгааг 2024 онд 78.8 хувьд хүргэнэ.

Зорилт: 2.5.3 Иргэдийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа 2019 онд 1431 байсныг 2024 онд 2587-д хүргэнэ.

Дээрх бодлогын баримт бичгээс гадна “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030”, “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025 он)”, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” зэрэг гэр бүлд чиглэсэн тодорхой зорилго бүхий арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сүүлийн хоёр жил монголын эдийн засгийн байдал хүндэрч, гэр бүлийн хөгжлийг дэмжих, ядуурлыг бууруулахад түлхэц болохуйц өөрчлөлт гараагүй байгаа нь нийгмийн халамжийн хөтөлбөрүүд нь өрх гэр бүлийг дэмжихэд үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөгжлийн хөтөлбөрүүд байх хэрэгцээ шаардлага урган гарч байна.

Өнөөгийн нөхцөл байдалд нийгмийн халамж дэмжлэг шаардлагагүй энгийн залуу гэр бүлийн хөгжлийг дэмжсэн үйлчилгээ дутмаг байна.

Гэр бүлийн хөгжил нь нийгмийн хөгжлийг тодорхойлогч гол хүчин зүйлийн нэг юм. Тиймээс ч улс орон бүр залуу гэр бүлийг дэмждэг. Дундговь аймаг төдийгүй Монгол улсад залуу гэр бүлийг хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд нь туслах, богино хугацааны тусламж үзүүлэх, тэтгэлэг олгох, байр орон сууцаар дэмжих, хөдөлмөрт бэлтгэх зэрэг залуу гэр бүлийг дэмжих тогтолцоо сул байна.

3.2. Залуу гэр бүлийн нийгэм, хүн ам зүй, эдийн засгийн төлөв байдал

Судалгаанд нийт 805 гэр бүл хамрагдсан бөгөөд үүнээс төрийн албан хаагч 423, хувиараа хөдөлмөр эрхлэгч 67, малчин 174, ажил эрхэлдэггүй 86, аж ахуй нэгжид ажил эрхэлдэг 55 гэр бүл тус тус хамрагдсан байна. Гэр бүлийн бүтцээр нь харвал дан гэр бүл 77.1, хэвийн гэр бүл 14.9, бусад хэвийн маягийн 8 хувь байна.

Хүснэгт 2.1 Залуу гэр бүлийн ерөнхий шинж байдал

Нийгмийн үзүүлэлт	Тоо	Хувь
Хүйс		
Эрэгтэй	290	36
Эмэгтэй	515	64
Боловсролын байдал		
Бага боловсрол	33	4
Бүрэн бус дунд	112	14
Бүрэн дунд	193	23.5
Техник мэргэжлийн	88	10.9
Бакалаврийн дээд	346	43
Магистр, түүнээс дээш	33	4.6
Гэрлэлтийн байдал		
Гэрлэлтийн баталгаатай	394	48.1
Гэрлээгүй, хамтран амьдарч байгаа	233	29
Гэрлэлтээ цуцлуулсан	153	19.9
Бэлэвсэн	25	3
Нийт	805	100

Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, хэрэгцээ үйлчилгээ
/Дундговь аймгийн жишээн дээр/

Судалгаанд оролцогчийн хүйсийн хувьд авч үзвэл эрэгтэй 36 хувь, эмэгтэй 64 хувь, харин боловсролын түвшингээр гол төлөв бүрэн дунд болон бакалаврын дээд боловсролтой иргэдийн эзлэх хувь 66.5% байна. Гэрлэлтийн байдлын хувьд 48.1 хувь нь гэрлэлтийн баталгаатай ажээ.

Хүснэгт 2.2 залуу гэр бүлийн хүн ам зүй, эдийн засгийн шинж

Үндсэн үзүүлэлт	Дундаж хувь	Хамгийн бага	Хамгийн их
Нас	27	18	35
Ам бүлийн тоо	3.5	1	8
Ажил эрхэлдэг хүний тоо	1.4	0	2
0-18 насны хүүхдийн тоо	2	0	6
Гэр бүлийн дундаж орлого	535492	140000	3700000
Малын тоо толгой	74.2	28	1300

Судалгааны үр дүнгээр оролцогчийн нас, ам бүлийн тоог дунджаар тооцоход 27 настай, ам бүл 3.5, хамгийн их нь 8 гишүүнтэй байна. Ажил эрхлэлтийн байдлыг авч үзэхэд гэр бүлд дунджаар 1 гишүүн ажилтай, хамгийн ихдээ 2 гишүүн тодорхой ажил эрхэлдэг, өрхийн дундаж орлого 535492 төгрөг байна.

Судлагдсан нийт залуу гэр бүлийн малын тоо толгойн дундаж 74.2, хамгийн олондоо 1300 малтай, хамгийн багадаа 28 тооны малтай байна.

Судалгааны дүнгээс залуу гэр бүлийн голлох эх үүсвэр нь цалин, хувиараа хөдөлмөр эрхэлсний орлого, хүүхдийн мөнгөний орлогогоос бүрдэж байна.

Залуу гэр бүлийн эрхэмлэдэг зүйлийг зорилтод гэр бүлээр харьцуулн авч үзэхэд дараах үр дүн харууллаа.

Хүснэгт 2.3 Залуу гэр бүлийн үнэт зүйл (хувиар)

Гэр бүлийн эрхэмлэл	Залуу гэр бүл		Зорилтод гэр бүл	
	Хувь	Эрэмбэ	Хувь	Эрэмбэ
Эрүүл мэнд	67.1	2	81.4	1
Үр хүүхэд	74.3	1	76.6	2
Гэр бүлийн амар амгалан бат бөх амьдрал	65	3	37.1	3
Боловсрол	31.4	6	25.9	4

Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, хэрэгцээ үйлчилгээ
/Дундговь аймгийн жишээн дээр/

Шударга ёс	32.6	5	16.1	6
Ажил мэргэжил	33.7	4	22.5	5
Хүний эрх	19.3	7	10.6	7
Найз нөхөд	14.8	9	5.2	9
Эд хөрөнгө	15.1	8	7.2	8
Авьяас чадвар	9.6	11	1.8	11
Нэр нөлөө бүхий танил тал	6.6	12		
Албан тушаал	10.4	10	1.9	10
Алдар цол, нэр хүнд	5	13	1.2	12

Залуу гэр бүлийн гишүүд нь үр хүүхэд, эрүүл мэнд, гэр бүлийн амар амгалан бат бөх амьдрал, ажил мэргэжил, шударга ёсыг илүү эрхэмлэдэг бол зорилтод гэр бүлийн үнэт зүйлд эрүүл мэнд, үр хүүхэд, гэр бүлийн амар амгалан бат бөх амьдрал, боловсрол, ажил мэргэжил гэж үзжээ. Үүнээс үзэхэд гэр бүлд тулгамдаж буй асуудлаас үл хамааран эрүүл мэнд, үр хүүхэд хамгийн чухал эрхэмлэл байгаа нь соёл уламжлалт хандлага, нийгмийн өөрчлөлт, хандлагаас ихээхэн хамаарч байж болох юм.

Хүснэгт 2.4 Залуу гэр бүлд нөлөөлж буй хүчин зүйлс, дундаж үзүүлэлтээр

№	Асуултууд	Залуу гэр бүл	Зорилтод гэр бүл
1	Бүх шатны төрийн үйлчилгээний хүнд суртал, авлига	3.97	3.57
2	Хууль тогтоомжийн тогтворгүй байдал	3.26	3.57
3	Өр зээл	4.74	4.06
4	Бэлчээр, байгалийн нөөцийн доройтол	3.65	3.24
5	Хүнсний аюулгүй байдал	3.74	3.87
6	Ажилгүйдэл	4.58	4.12
7	Ядуурал	2.45	4.19
8	Архидалт	3.31	3.78
9	Жендэрийн хэвшмэл ойлголт	2.06	3.07
10	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	3.19	3.79
11	Баян хоосны ялгаа	2.96	3.79
12	Боловсролын чанар хүртээмж	2.17	3.62
13	Намуудын талцал	3.31	3.81

Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, хэрэгцээ үйлчилгээ
/Дундговь аймгийн жишээн дээр/

14	Шударга ёс	2.56	3.88
15	Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт	4.01	3.81
Тайлбар: 1-огт нөлөөлөхгүй, 2- нөлөөлөхгүй, 3-дунд зэрэг, 4-ер нь нөлөөлнө, 5 маш их нөлөөлнө.			

Залуу гэр бүлд нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын зүйлүүдийн ихэнх нь дунд зэрэг нөлөөлдөг бөгөөд эдгээрээс өргөн хэрэглээний барааны өсөлт, өр зээл мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг байна. Харин жендэрийн хэвшил ойлголтийн талаарх ойлголт мэдлэг дутмаг, нөгөө талаас жендэрийн хэвшмэл ойлголтыг хүлээн зөвшөөрдөг байх талтай.

Залуу гэр бүлд өр зээл, өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт, бүх шатны төрийн байгууллагын үйлчилгээний хүнд суртал хамгийн их сөргөөр нөлөөлж байхад, зорилгод бүлгийн гэр бүлд ядуурал, ажилгүйдэл, өр зээл хамгийн их сөргөөр нөлөөлж байна.

3.3. Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, хэрэгцээ, үйлчилгээ

Судалгаанд хамрагдсан нийт 805 гэр бүлийн эдийн засаг, амьжиргаа, нийгмийн харилцаа, сэтгэл зүй болон эрүүл мэндийн тулгамдаж буй асуудал, хэрэгцээг судлав.

Хүснэгт 2.5 Залуу гэр бүлийн эдийн засаг, амьжиргааны байдал, дундаж үзүүлэлтээр

№	Асуултууд	Залуу гэр бүл	Зорилгод гэр бүл
1	Хоол хүнс тэжээл	3.78	3.22
2	Амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх байдал	2.77	3.41
3	Өрхийн сууцны байдал	3.02	2.84
4	Амьжиргааны түвшин	2.48	2.95
5	Нийгмийн даатгал	3.75	2.69
6	Халамжийн тэтгэмж	3.20	2.68
7	Амьдрах таатай орчин	2.36	2.68
8	Хүүхдийн суралцах нөхцөл	3.82	2.69
9	Цалин, орлого	2.16	2.84
10	Гэр бүлээрээ баяр ёслол, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх байдал	3.36	2.41
11	Бизнес эрхлэх боломж	2.54	2.77

Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, хэрэгцээ үйлчилгээ
/Дундговь аймгийн жишээн дээр/

12	Газар өмчлөх эрхээ эдлэх боломж	3.87	2.57
Тайлбар: 1-маш муу, 2-муу, 3-дунд зэрэг, 4-сайн, 5-маш сайн.			

Судалгааны дүнгээс үзэхэд залуу гэр бүлийн цалин орлого, амьжиргааны түвшин, амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх байдал, бизнес эрхлэх байдал нь хангалтгүй, тааруухан хэмээн хариуллаа. Харин зорилгод бүлгийн гэр бүлтэй харьцуулахад хоол хүнс тэжээл, газар өмчлөх боломж, хүүхдийн суралцах нөхцөл, нийгмийн даатгал нь хэвийн буюу сайн гэж үзсэн байна.

Залуу гэр бүлд эдийн засаг, амьжиргааны дараах асуудлууд тулгамдсан шинжтэй байна. Тухайлбал,

- Цалин орлогоо нэмэгдүүлэх (42 хувь буюу ойролцоогоор 3 гэр бүл тутмын нэг нь)
- Амьжиргааны түвшин (27.8 хувь буюу ойролцоогоор 4 гэр бүл тутмын нэг нь)
- Бизнес эрхлэх боломж (22.5 хувь буюу ойролцоогоор 5 гэр бүл тутмын нэг нь)

Хүснэгт 2.6 Залуу гэр бүлийн харилцааны нөхцөл байдлын үнэлгээ, дундаж үзүүлэлтээр

№	Асуултууд	Залуу гэр бүл	Зорилгод гэр бүл
1	Эхнэр, нөхрийн харилцаа	3.80	3.55
2	Ээж, хүүхдийн харилцаа	4.36	3.99
3	Аав, хүүхдийн харилцаа	4.22	3.70
4	Эцэг, эх багшийн харилцаа	3.88	3.63
5	Үе тэнгийхний харилцаа	3.75	3.70
6	Хүүхэд багштайгаа харилцах харилцаа	3.96	3.65
7	Хадам аав ээжтэйгээ харилцах харилцаа	3.73	3.41
8	Хамаатан садантай харилцах харилцаа	3.89	3.63
9	Найз нөхөдтэйгээ харилцах харилцаа	4.17	3.74
10	Ханийн хайр халамж	3.81	3.39
Тайлбар: 1-маш муу, 2-муу, 3-дунд зэрэг, 4-сайн, 5-маш сайн			

Залуу гэр бүлийн харилцааны нөхцөл байдлыг судлахад ээж, хүүхдийн болон аав, найз нөхөдтэйгээ харилцах харилцааны дундаж үзүүлэлт 4.17-4.36 хооронд хэлбэлзэж байгаа нь дурдсан асуудлуудаар асуудал гардаггүйг илтгэж байна. Харин хадам аав

Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, хэрэгцээ үйлчилгээ
/Дундговь аймгийн жишээн дээр/

ээжтэйгээ харилцах харилцаа, үе тэнгийхний харилцаа, эхнэр нөхрийн харилцаа нь бусад үзүүлэлтүүдээс бага байгааг нь цаашид анхааран, харилцааг дэмжсэн олон талт үйл ажиллагааг явуулах нь зүйтэй юм.

Залуу гэр бүлийн харилцааг зорилтод гэр бүлийнтэй харьцуулахад тулгамдаж буй асуудал нь харьцангуй бага ч дараах асуудлууд тулгамдсан шинжтэй байна. Үүнд:

- Эхнэр нөхрийн хоорондын хэрүүл, маргаан үл итгэлцэл (21.1 хувь буюу ойролцоогоор 5 гэр бүл тутмын нэг нь)
- Хүүхдийн цахим донтолт (17.6 хувь буюу ойролцоогоор 7 гэр бүл тутмын нэг нь)
- Хүүхдэд тавих анхаарал халамж багасах, орхигдуулах (14.6 хувь буюу ойролцоогоор 8 гэр бүл тутмын нэг нь)

Залуу гэр бүлийн харилцааны хувьд хэрүүл маргаан, хүүхдэд тавих анхаарал багасах, орхигдуулах нь түгээмэл бөгөөд үүнээс үүдэлтэй хүүхэд гэмт хэрэгт холбогдох, цахим донтолтод өртөх асуудал гарч байна.

Хүснэгт: 2.7 Залуу гэр бүлийн сэтгэл зүйн байдлын үнэлгээ, дундаж үзүүлэлтээр

№	Асуултууд	Залуу гэр бүл	Зорилтод гэр бүл
1	Өөртөө итгэлгүй, идэвхгүй байдал	2.11	2.87
2	Үрэлгэн зан	3.06	2.93
3	Хоол, амралтын буруу зуршил	2.63	2.90
4	Залхуу хойрго	2.11	2.60
5	Эрүүл мэндээ, биеэ үл хайхрах	3.34	3.06
6	Тооцоо төлөвлөөгүй байдал	2.63	2.78
7	Стресс бухимдал	3.28	3.10
8	Санаа зовнил	3.17	3.22
9	Сэтгэл гутрал	2.21	2.91
10	Айдас түгшүүр	2.45	2.70
Тайлбар: 1-маш муу, 2-муу, 3-дунд зэрэг, 4-сайн, 5-маш сайн			

Залуу гэр бүлийн сэтгэл зүйн байдлыг авч үзэхэд өөртөө итгэлгүй, идэвхгүй байдал, залхуу хойрго, сэтгэл гутрал, айдас түгшүүр, хоол амралтын буруу зуршил нь бусад үзүүлэлттэй харьцуулахад доогуур илрэлтэй буюу сэтгэл зүйн ийм үзэгдэлд өртөх нь бага

Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, хэрэгцээ үйлчилгээ
/Дундговь аймгийн жишээн дээр/

ажээ. Харин эрүүл мэндээ үл хайхрах, стресс бухимдал, үрэлгэн зан, санаа зовнилын илрэл дунд гэдэг хэмжигдэхүүнд хамааруулан хариулжээ.

Залуу гэр бүлийн сэтгэл зүйн байдлыг зорилтод гэр бүлтэй харьцуулахад тулгамдаж буй асуудал нь бага ч дараах асуудал байна. Үүнд:

- Гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндээ, биеэ үл хайхрах байдал (41 хувь буюу ойролцоогоор 3 гэр бүл тутмын нэг нь)
- Стресс, бухимдал (21 хувь буюу ойролцоогоор 4 гэр бүл тутмын нэг нь)

Стресс бухимдал бол хүнийг сэтгэлийн хямралд оруулах, эвгүйцэл төрүүлэх, зан үйлд өөрчлөлт оруулан, ажил амьдралын амжилт бүтээлийг бууруулдаг төдгийгүй бие махбодь болон сэтгэцийн эрүүл мэндэд муугаар нөлөөлж, сэтгэцийн өөрчлөлтийг үүсгэдэг байна.

Хүснэгт: 2.8 Залуу гэр бүлийн эрүүл мэндийн одоогийн нөхцөл байдлын үнэлгээ, дундаж үзүүлэлтээр

№	Асуултууд	Залуу гэр бүл	Зорилтод гэр бүл
1	Суурь өвчлөл	2.10	2.56
2	Эрүүл хүнсний хэрэглээ	3.62	3.06
3	Эмнэлгийн үзлэг, шинжилгээнд хамрагдалт	3.51	2.63
4	Эмийн хэрэглээ	2.88	2.73
5	Бэлгийн замын халдварт өвчин	1.62	1.46
6	Дасгал хөдөлгөөн, спортоор хичээллэх байдал	2.16	2.38
7	Компьютер утасны хэрэглээ	3.28	2.94
8	Амин дэмийн хэрэглээ	2.53	2.33

Тайлбар: 1-маш муу, 2-муу, 3-дунд зэрэг, 4-сайн, 5-маш сайн

Залуу гэр бүлийн эрүүл мэндийн хувьд бэлгийн замын халдварт өвчин, суурь өвчлөл, дасгал хөдөлгөөн, спортоор хичээллэх байдал зэргийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал бага байна. Харин эрүүл хүнсний хэрэглээ, эмнэлгийн үзлэг шинжилгээ, компьютер утасны хэрэглээ нь залуу гэр бүл болон зорилтод гэр бүлийн аль алинд нь анхаарал хандуулах асуудал болж байна.

Чанарын судалгаа:

Эксперт ярилцлага 1

Залуу гэр бүлд ямар төрлийн нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ хэрэгтэй вэ? Үүний ач холбогдол юу вэ? Үүнийг нэрлэнэ үү.

1. Залуу гэр бүлийн хэрэгцээ шаардлага 1.2-3 насны цэцэрлэг элсэлт залуу гэр бүлийн ажлын байраар хангах түүнд дэмжлэг үзүүлэх 2. Орон байрны нөхцөл хангамжийг нэмэгдүүлэх /Тавигдах шаардлага залуу гэр бүл хамрагдах боломжтой байх/ 3. Гэр бүл төлөвлөлт хийх сэтгэл зүйг бэлтгэх 4. Төрсний дараах сэтгэл зүйд анхаарах 5. Гэр бүлийн үнэ цэнийг ойлгуулах түүнд дэмжлэг үзүүлэх 6. Залуу гэр бүлийн сэтгэл зүйн орчинг дэмжих сэтгэл зүйн модуль сургалт бэлтгэх 7. Залуу гэр бүлийн нийгмийн оролцоог дэмжих Үүний ач холбогдол: Сэтгэл зүйчид хандаж буй Залуу гэр бүлийн дийлэнх хувь нь ажилгүйдэл, архидалт, гэр бүл салалт, төрсний дараах сэтгэл гутралд орсон үйлчлүүлэгч байдаг. Гэр бүлийн боловсрол сул учраас өөрийн гэр бүлийн таатай орчин сэтгэл зүйн аюулгүй холбоо харилцааг бий болгож чадаагүйгээс зөрчил үүссэн тэр зөрчил даамжирсан байдаг. Дээрх үйл ажиллагааг хийснээр Сайн аав Сайн ээж сайхан гэр бүл гэсэн ойлголтод залуу гэр бүлийг бэлтгэж урт хугацаандаа гэр бүлийг тогтвортой хүүхдэд ээлтэй орчинд бэлтгэнэ гэдэгт итгэлтэй байна. Хувь хүн бүрийн сэтгэл зүйд анхаарах нь чухал гэж үзэж байна. Түүнд дэмжлэг үзүүлэх хамгийн том хөрөнгө оруулалт байх болно

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын сэтгэл зүйч

Эксперт ярилцлага 2

Залуу гэр бүлд ямар төрлийн нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ хэрэгтэй вэ? Үүний ач холбогдол юу вэ? Үүнийг нэрлэнэ үү.

Залуу гэр бүлд гэр бүл төлөвлөлттэй холбоотой зөвлөгөө мэдээлэл дутмаг байгаа нь эмэгтэйчүүдийн хувьд төрсний дараах сэтгэл гутрал урт хугацаагаар үргэлжлэх гэр бүлийн гишүүдийн таатай уур амьсгал өөрчлөгдөхөд нөлөөлж байгаа судалгаа байдаг. 2018 онд хийсэн судалгаагаар төрж байгаа эмэгтэйчүүдийн хувьд 2 дахь төрөлтөн дээр илүү сэтгэл түгшилттэй байдаг гэсэн үр дүн гарсан. Нөгөө талаар бие хүний хэв шинжийн хувьд невротик өндөртэй эмэгтэй төрсний дараах сэтгэл гутралд удаан хугацаагаар орох цаашилаад бэлгийн амьдралдаа сэтгэл хангалуун бус байдлыг мэдэрдэг гэсэн үр дүн гарч байсан. Тэгэхээр гэр бүл төлөвлөлтөд гэр бүлийн гишүүдийн сэтгэл

зүйн бэлтгэл чухал нөлөөтэй учраас сайн ярилцаж гэр бүлийн сэтгэл зүйчээс зөвлөгөө авах, цаашилаад гэр бүлийн сургалтуудад хамрагдах шаардлагатай. Байгууллага аж ахуй нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлөөс гэр бүлийн сургалтуудыг тогтмол хугацаанд зохион байгуулдаг байх нь гэр бүлд сэтгэл зүйн таатай харилцааг бий болгох бас нэг суурь болно

Залуу гэр бүлд тулгамдаж байгаа бас нэг асуудал нь өрхийн санхүүгийн асуудал. Ихэнх залуу гэр бүлүүд өрхийн санхүүгээ төлөвлөдөггүй, хуримтлал, хадгаламжгүй байгаа нь нийгэм сэтгэл зүйн таагүй уур амьсгал гэр бүлийн зөрчил маргаан салалт үүсэх нэг шалтгаан болж байгаа. Нэг талаас төлөвлөдөггүй аль эсвэл гэр бүлд эдийн засгийн хүчирхийлэл үйлддэг байдал нь эмэгтэй эрэгтэй аль аль талдаа сэтгэл зүйн суурь хэрэгцээ бол аюулгүй мэдрэмжийг алдагдуулж байдаг. Дээрээс нь банк болон банк бус санхүүгийн байгууллагаас ипотека, хэрэглээний болон цалингийн зээлтэй байдаг нь төлөвлөлт хийдэггүй гэр бүл санхүүгийн дарамт болох эрсдэлтэй байна

Дундговь аймгийн Мандал сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч

Эксперт ярилцлага 3

Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэхэд ямар төрлийн дэмжлэгийг орон нутгийн зүгээс үзүүлэх шаардлагатай вэ?

Ажил хөдөлмөр эрхлэлт, Орон байр Хүүхэд харах хүн цэцэрлэг Нийгмийн тогтолцооны дэмжлэг дутмаг Мөн өөрсдийн зүгээс идэвх оролцоо сул залхуу Аливаад хандах хандлага сул аргацаах аргалах хандлага давамгайлдаг Бүтээлч сэтгэлгээгүй бэлэнчлэх амар хялбарыг хүлээдэг Цахим болон мөрийтэй тоглоомд хэт их орсон Гэр бүлийн харилцааны талаар боловсроогүй хариуцлага хүлээх чадвар дутмаг Хосууд хоорондоо ярилцаж ойлголцох, шийдвэр гаргах тал дээр сул Гэр бүлийн уур амьсгал, хүүхэд хүмүүжүүлэх тал дээр анхаардаггүй ... дээрх шалтгаануудаас шалтгаан гэр бүл салалт нэмэгдэж байгаа энэ нь хүлээцгүй, гэр бүлд үнэт зүйл тогтоогүй, хариуцлагагүй байгаатай холбоотой.

Орон нутгийн зүгээс авах арга хэмжээ: Залуу гэр бүлүүдэд бүртгүүлэх үйл явцаас нь авхуулаад гэр бүлийн боловсрол хариуцлагын талаар ойлгуулах сургалт нөлөөллийн ажил хийх Залуучуудын шинэлэг санаа амжилт бүтээлийг дэмжих Байгууллагуудын залуучуудыг дэмжих тал дээр анхаарч ахмад үеийнхэнд тэднийг илүү дэмжих урмыг нь хугалахгүй байх тал дээр анхаарах талаас сануулах, Залуу гэр бүлүүдэд гэр бүлийн боловсрол мэдээлэл, эерэг харилцааг хэвшүүлж дадуулах тал дээр анхаарах Тэдний

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Орон байрны асуудалд дэмжлэг үзүүлэх Хүүхэд харах үйлчилгээ, цэцэрлэг сургуулийн хүртээмж чанарыг сайжруулах

Залуу гэр бүлийн харилцааны нөхцөл байдал нь үл ойлголцол, үл хүндлэл, хариуцлагагүй байдал, хоорондын амьд харилцаа сул, гэр бүлийн боловсрол дутмаг, цахим тоглоом, амьдралын идэвхгүй байдал зэргээс шалтгаалж байгаа байх Цаашид гэр бүлийн боловсрол бусдыг ойлгох, ярилцах чадвар, хүлээцтэй байх, хариуцлагатай байх, муу зурилуудаасаа татгалзах, гэр бүлдээ цаг зав гаргах ... зэрэг эерэг хандлага, эерэг өөрчлөлтүүдийг хийж идэвхитэй бүтээлч амьдар хэрэгтэй

Төгөлдөршил хувь хүний хөгжлийг дэмжих төрийн бус байгууллагын төлөөлөл

Эксперт ярилцлага 4

Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэхэд ямар төрлийн дэмжлэгийг орон нутгийн зүгээс үзүүлэх шаардлагатай вэ?

Залуу гэр бүлд тулгамдаж байгаа нийтлэг асуудал бол ажил эрхэлдэг залуу гэр бүлд бага насны хүүхэд харах асуудал маш ихээр тулгамддаг. Тогтвор суурьшилтай ажиллахад ажлын байр дутмаг, ажлын хөлс бага, зээл тусламжинд хамрагдах зээлийн нөхцөл шаардлага өндөр учир хамрагдаж чаддаггүй, орон байрны асуудал тулгамдах, хадмуудтайгаа хамт амьдрах болж, цаашилаад энэ асуудал нь хадам талын нөлөөлөл их болсоноор гэр бүлийн харилцаанд зөрчил маргаан үүсэх нөхцөл нь болж байгаа. Мөн орон нутгийн зүгээс залуу гэр бүлийн бизнесийг дэмжих, сум хөгжүүлэх сангийн зээлэнд хамрагдаж нөхцөл боломжоор дэмжих

Сайнцагаан сумын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Эксперт ярилцлага 5

Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэхэд ямар төрлийн дэмжлэгийг орон нутгийн зүгээс үзүүлэх шаардлагатай вэ?

Сүүлийн үед залуу гэр бүлүүд гэрлэлтээ цуцлуулах нь өмнөх онуудаас ихсэж байгаа, энэ тал дээр өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байхад, залуу гэр бүлд дараах асуудал тулгамддаг учраас эдгээр асуудлаан шийдэж чадахгүй байгаад гэр бүл цуцалж байна гэж харж байна. Үүнд:

1. Өөр орчинд өсөж төлөвшсөн хүмүүс тодорхой хугацааны дараа аливаа асуудал дээр зөрчилдөхдөө асуудлаа шийдвэрлэхдээ нэг нэгнээ хүлээн зөвшөөрч, хүлээцтэй хандаж чадахгүй асуудлыг дэвэргээж дамжуулдаг.
2. Гэр бүлийн амьдралд хадмуудын оролцоо их байдаг.

Дундговь аймгийн өмгөөлөгчдийн холбооны тэргүүн, өмгөөлөгч

Залуу гэр бүлийн хэрэгцээ, үйлчилгээ

Залуу гэр бүлд дараах хэрэгцээ шаардлага тулгамдаж байгааг судалгааны дүн харуулах юм. Үүнд:

- Тогтвор суурьшилтай ажлын байр нэмэгдүүлэх
- Цалин орлогоо нэмэгдүүлэх
- Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх
- Орон сууцтай болох
- Амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх
- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих
- Бага хүүтэй зээлд хамрагдах, санхүүгийн дэмжлэг туслалцаа авах зэрэг болно.

Гэр бүлийн харилцааг зохицуулах хууль эрх зүйн баримт бичгүүдийг судалж үзэхэд гол төлөв зорилгод гэр бүлийг дэмжсэн үйлчилгээг үзүүлж байгааг цаашид анхаарах нь зүйтэй юм.

Залуу гэр бүлийг дэмжсэн хөгжлийн үйлчилгээний хувилбарыг хэрэгжүүлэх шаардлагатай.

1. Залуу гэр бүлийн гишүүний орлогыг нэмэгдүүлэх зорилгоор аж ахуй нэгж байгууллагатай хамтран сургалтуудыг зохион байгуулах
2. Залуу гэр бүлийн харилцаан тулгамдаж буй асуудлыг даван туулахад дэмжлэг үзүүлэх сэтгэл зүйн зөвлөгөө өгөх
3. Гэр бүлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах
4. Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийг байгуулах

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ҮР ДҮН

- ✓ Судалгааны үр дүнгээс залуу гэр бүлийн голлох эх үүсвэр нь цалин, хувиараа хөдөлмөр эрхэлсний орлого, хүүхдийн мөнгө бөгөөд залуу гэр бүлийн хамгийн чухал эрхэмлэх зүйл нь үр хүүхэд, эрүүл мэнд, гэр бүлийн амар амгалан бат бөх амьдрал, ажил мэргэжил, шударга ёсыг илүү эрхэмлэдэг гэж үзжээ.
- ✓ Залуу гэр бүлд 42 хувь буюу ойролцоогоор 3 гэр бүл тутмын нэг нь цалин орлогоо нэмэгдүүлэх, 27.8 хувь буюу ойролцоогоор 4 гэр бүл тутмын нэг нь амьжиргааны түвшингээ сайжруулах, 22.5 хувь буюу ойролцоогоор 5 гэр бүл тутмын нэг нь бизнес эрхлэх боломж, зээлээ төлөх зэрэг эдийн засаг амьжиргааны асуудал гардаг.
- ✓ Гэр бүлийн харилцааны хувьд хэрүүл маргаан, хүүхдэд тавих анхаарал багасах, орхигдуулах нь түгээмэл бөгөөд үүнээс үүдэлтэй хүүхэд гэмт хэрэгт холбогдох, цахим донтолтод өртөх асуудал түгээмэл ажээ.
- ✓ Судалгаанд оролцогчдын 41 хувь буюу ойролцоогоор 3 гэр бүл тутмын нэг нь гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндээ, биеэ үл хайхрах байдал, 21 хувь буюу ойролцоогоор 4 гэр бүл тутмын нэг нь стресс, бухимдалтай байгаа бол эрүүл хүнсний хэрэглээ, эмнэлгийн үзлэг шинжилгээ, компьютер утасны хэрэглээ зэрэг эрүүл мэндийн асуудлууд тулгардаг байна.
- ✓ Залуу гэр бүлд тогтвор суурьшилтай ажиллах ажлын байрыг нэмэгдүүлэх, орлогоо нэмэгдүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах, бага хүүтэй зээлд хамрагдах, санхүүгийн дэмжлэг туслалцаа авах хэрэгцээ шаардлага байна.
- ✓ Залуу гэр бүлийн амьжиргаа, эдийн засгийн нөхцөл байдалд давхардсан тоогоор өдөрт тутмын хоол хүнсээ худалдан авах, орон сууцны нөхцөлөө сайжруулах, байр орон сууц худалдан авах, газар өмчлөх зэрэг асуудал тулгамддаг байна.
- ✓ Залуу гэр бүлд тогтвор суурьшилтай ажлын байр нэмэгдүүлэх, орлогоо нэмэгдүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах, орон гэртээ болох, сууцаа сайжруулах, гэр бүлд чиглэсэн сэтгэл зүйн зөвлөгөө, гэр бүлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах, хамруулах зэрэг хэрэгцээ шаардлага байна.

ТАВДУГААР БҮЛЭГ: ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Гэр бүлийн тухай хууль тогтоомжид Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, бусад актаас бүрддэг. Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 11-д “Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаан үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” хэмээн тогтоосон бөгөөд энэ нь эрэгтэй, эмэгтэй хүн сайн дурын үндсэн дээр тэгш эрхтэйгээр гэрлэх эрхтэйг хуульчлан баталгаажуулсан байна. Түүнчлэн, гэр бүлийн ашиг сонирхлыг хамгаалахад төр үүрэг хүлээх ёстойг тодорхойлж өгчээ.

Гэр бүлийн тухай хуулиар гэрлэлт, гэр бүлийн харилцаанд тэгш эрх, сайн дурын харилцаа, үл ялгаварлах, гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаалах, түүний эрх ашиг сонирхлыг нь нэн тэргүүнд хамгаалах үндсэн зарчмуудыг тодорхойлсон. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль зэрэг холбогдох хууль нь гэр бүл дэх эрх тэгш байдал, хүүхдийн эрх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, гэр бүл дэх хүүхэд хамгаалал, талуудын үүрэг оролцоог тодорхойлж, төрийн зүгээс үзүүлэх үйлчилгээг нарийвчлан тодорхойлсон.

“Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030”, “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025 он)”, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичиг нь гэр бүлд чиглэсэн тодорхой зорилго бүхий арга хэмжээг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Түүнчлэн төрөөс халамжийн хөтөлбөрүүдээрээ гэр бүлийн хөгжлийг дэмжихэд анхаарч байна.

Сүүлийн хоёр жил монголын эдийн засгийн байдал хүндэрч, гэр бүлийн хөгжлийг дэмжих, ядуурлыг бууруулахад түлхэц болохуйц өөрчлөлт гараагүй байгаа нь нийгмийн халамжийн хөтөлбөрүүд нь өрх гэр бүлийг дэмжихэд үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөгжлийн хөтөлбөрүүд байх хэрэгцээ шаардлага урган гарч байна.

Өнөөгийн нөхцөл байдалд нийгмийн халамж дэмжлэг шаардлагагүй энгийн залуу гэр бүлийн хөгжлийг дэмжсэн үйлчилгээ дутмаг байна.

Монгол Улсын төрөөс залуу гэр бүлийг дэмжих талаарх дээрх урт болон богино хугацааны бодлогын баримт бичгүүд хэрэгжсэн байгаа ч өнөөдөр залуу гэр бүлд амины орон сууц барих, газар тариалан, бизнес эрхлэхэд зориулан жижиг зээл олгох, залуу эцэг, эхийг дэмжин туслах эдийн засаг, эрх зүйн орчин бүрдээгүй байгаа нь бие даан амьдрах,

төлөвших үйл явцад хүндрэл учруулж байна. Иймд залуу гэр бүлийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, тогтвортой ажлын байраар хангаснаар өрхийн орлого, амьжиргаагаа дээшлүүлж ахуй нөхцлөө сайжруулах, гэр орноо төвхнүүлэх зэрэг олон асуудлаа шийдэх чадавхыг бэхжүүлэх нь чухал байна.

Судалгааны үр дүнгээс залуу гэр бүлийн голлох эх үүсвэр нь цалин, хувиараа хөдөлмөр эрхэлсний орлого, хүүхдийн мөнгө бөгөөд залуу гэр бүлийн хамгийн чухал эрхэмлэх зүйл нь үр хүүхэд, эрүүл мэнд, гэр бүлийн амар амгалан бат бөх амьдрал, ажил мэргэжил, шударга ёсыг илүү эрхэмлэдэг гэж үзжээ.

Залуу гэр бүлд 42 хувь буюу ойролцоогоор 3 гэр бүл тутмын нэг нь цалин орлогоо нэмэгдүүлэх, 27.8 хувь буюу ойролцоогоор 4 гэр бүл тутмын нэг нь амьжиргааны түвшингээ сайжруулах, 22.5 хувь буюу ойролцоогоор 5 гэр бүл тутмын нэг нь бизнес эрхлэх боломж, зээлээ төлөх зэрэг эдийн засаг амьжиргааны асуудал гардаг.

Гэр бүлийн харилцааны хувьд хэрүүл маргаан, хүүхдэд тавих анхаарал багасах, орхигдуулах нь түгээмэл бөгөөд үүнээс үүдэлтэй хүүхэд гэмт хэрэгт холбогдох, цахим донтолтод өртөх асуудал түгээмэл ажээ.

Судалгаанд оролцогчдын 41 хувь буюу ойролцоогоор 3 гэр бүл тутмын нэг нь гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндээ, биеэ үл хайхрах байдал, 21 хувь буюу ойролцоогоор 4 гэр бүл тутмын нэг нь стресс, бухимдалтай байгаа бол эрүүл хүнсний хэрэглээ, эмнэлгийн үзлэг шинжилгээ, компьютер утасны хэрэглээ зэрэг эрүүл мэндийн асуудлууд тулгардаг байна.

Залуу гэр бүлд тогтвор суурьшилтай ажиллах ажлын байрыг нэмэгдүүлэх, орлогоо нэмэгдүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах, бага хүүтэй зээлд хамрагдах, санхүүгийн дэмжлэг туслалцаа авах хэрэгцээ шаардлага байна.

Залуу гэр бүлийн амьжиргаа, эдийн засгийн нөхцөл байдалд давхардсан тоогоор өдөрт тутмын хоол хүнсээ худалдан авах, орон сууцны нөхцөлөө сайжруулах, байр орон сууц худалдан авах, газар өмчлөх зэрэг асуудал тулгамддаг байна.

Залуу гэр бүлд тогтвор суурьшилтай ажлын байр нэмэгдүүлэх, орлогоо нэмэгдүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах, орон гэртээ болох, сууцаа сайжруулах, гэр бүлд чиглэсэн сэтгэл зүйн зөвлөгөө, гэр бүлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах, хамруулах зэрэг хэрэгцээ шаардлага байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. ШУА-ийн ФСХ, УБИС Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, Улаанбаатар, 2010 он
2. “Монгол гэр бүлийн бүтэц, хэв маяг, харилцааны онцлог, тулгамдаж буй асуудал”, Улаанбаатар, 2012 он
3. Дундговь аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016-2020 оны статистик мэдээлэл
4. УИХ, Залуу гэр бүлийг дэмжих төрийн бодлогын талаар бусад орны зохицуулалт, эрх зүйн орчны асуудал /харьцуулсан судалгаа/ Улаанбаатар, 2013
5. УИХ-ын 16-р тогтоолын хавсралт, “Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого” Улаанбаатар, 2003 он
6. Платон.Законы Соч.в 3 т. М.1972.т. 3. Ч. Стр. 148-150
7. Бүрэнжаргал.Т, Гэр бүлийн социологи, Улаанбаатар, 2005 он
8. Цэвэл.Я, Монгол хэлний тайлбар толь
9. Монгол Улсын Иргэний хуулийн 14-15-р зүйл
10. НХХЯ - Хүн ам, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн үзүүлэлтүүд, 2010 он.
11. ОУХБ, НХХЯ - Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаархи ОУХБ-аас гаргасан баримт бичгийн эмхэтгэл 2006 он
12. Меньшутин М.П “Залуу гэр бүлд тусламж” УБ, 1990 он
13. Хавх.Н “Эр хүнд оюун санааны, эм хүнд сэтгэлийн баялагийг байгаль илүү заяажээ” УБ, 1994 он
14. Мандах З. “Орчин үеийн гэр бүлийн харилцааны зарим асуудал” 2010
15. “Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай” хууль, 2006
16. Оюун-Эрдэнэ.Б, Гэр бүлийн боловсрол, Улаанбаатар, 2017 он
17. Монгол гэр бүлийн асуудал, хэрэгцээ үйлчилгээний хувилбар” судалгааны тайлан, Улаанбаатар, 2018 он
18. Оюун-Эрдэнэ Б. “Залуу гэр бүлд зориулсан сургалтын модуль” 2020 он
19. Оюун-Эрдэнэ Б. “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” судалгааны тойм УБ, 2010
20. Намжил Т. Ц.Энхтүвшин “Гэр бүлийн хөгжлийн асуудал”, Улаанбаатар, 2016 он
21. 1212.mn
22. [йЦр://b12peг№огк.шп/пеГ№огк/1op1c/8Йо^/8949/raee/1](http://b12peг№огк.шп/пеГ№огк/1op1c/8Йо^/8949/raee/1) Залуу насны ангилалын

талаарх бэсрэг шинжилгээ

23. [Н11р://ec.europa.eu/you11n/you11n-1п-ас11оп-ргоцга1П1пе/с1ос74 ен.Бг](http://ec.europa.eu/you11n/you11n-1p-act10p-процга111pe/c1oc74 en.BT)
24. [Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль](#)
25. [Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр](#)